

ОУИТБС-д анхаарлаа хандуулъя

*Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын
талаарх
Иргэний нийгмийн үзэл бодол ба санал зөвлөмжүүд*

2006 оны 10 дугаар сар

DDC
622
0-273



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,
Монгол Улс
Утас: 976-11-313207
Факс: 976-11-314857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@soros.org.mn

Энэхүү номын монгол орчуулгыг Нээлттэй Нийгэм Форумаас эрхлэн хийсэн ба орчуулгын зохиогчийн эрхийг Нээлттэй Нийгэм Форум эзэмшинэ.
© 2007

Орчуулсан: Г. Батбаяр
Хянан тохиолдуулсан: Ц. Гомбосүрэн
Н. Дорждарь

Publish What You Pay
/Төлснөө Нийтэл/
c/o Open Society Foundation-London
4th Floor, Cambridge House
100 Cambridge Grove
London W6 0LE
United Kingdom
Tel: +44 (0) 20 7031 0204
Fax: +44 (0) 20 7031 0201
E-mail: coordinator@publishwhatyoupay.org

Revenue Watch Institute
/Орлогын Ажиглагч Хүрээлэн/
400 West 59th Street
New York, NY 10019 USA
Tel: 212 548 0600
Fax: 212 548 4607
www.revenuwatch.org

ISBN 99929-0-192-6

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

ОРЧУУЛГЫН ҮГ

Монгол улс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага хэмээх байгалийн их баялагтай дэлхийн 20 гаруй улс орон нэгдэн орсон хөдөлгөөнд 2006 оны 1 дүгээр сард нэгдэж байгаагаа албан ёсоор мэдэгдсэн билээ. Төр засаг уул уурхайн салбараас олох орлогоо, уул уурхайн компаниуд харин төр засагт төлсөн татвараа нийтэд мэдээлдэг, улмаар уг хоёр мэдээлсэн тоо хэмжээ ижил тэнцүү байх энгийн зарчим дээр үндэслэн уг салбарын эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг иргэдэд ойлгуулж, авилгал үүсэх нөхцлийг хязгаарлах зорилготой уг санаачлага олон улсын түвшинд хэрхэн хэрэгжиж байгаа талаар энэхүү судалгаанд тусгасан болно. Тодорхой улс орнуудад хэрэгжилт ямар түвшинд байгаа, ямар хүндрэл бэрхшээл учирч байгааг иргэний нийгмийн байр сууринаас тайлбарласан болно.

Уг судалгаа нь Монголд дээрх санаачлагыг хэрэгжүүлэхэд тус дэм болно гэдэгт найдаж байна. Цаашид ч иргэний нийгмийн зүгээс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг бодит ажил болгоход дэмжлэг үзүүлэх үүднээс нарийвчилсан ажиглалт хийж, дүгнэлт гарган, үйл явцыг түргэсгэхэд чиглэсэн бүтээлч саналуудыг дэвшүүлэх болно.

Судалгааг Орлогын Ажиглагч Хүрээлэн (Revenue Watch Institute), “Төлснөө нийтэл” хэмээх иргэний нийгмийн олон улсын эвсэл (Publish What You Pay Campaign)-ээс хамтран гүйцэтгэсэн болно. Судалгааны тайланг монгол хэлнээ бэлтгэн гаргахад оролцсон орчуулагч, редактор нарт талархал илэрхийлж байна.

П. Эрдэнэжаргал

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх Захирал

ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ

Газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн үйлдвэрлэлээс бий болгосон асар их орлогын ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах нь “нөөцийн хяслан”-гаас сэргийлээд зогсохгүй тэдгээр орлогыг ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг бий болгоход чиглүүлэн ашиглалтыг дээшлүүлэхэд амин чухал үүрэгтэй болохыг сүүлийн арван жилд улам бүр сайн мэддэг болоод байна. 2002 оны 9 дүгээр сард Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгыг (ОҮИТБС) эхлүүлэхэд энэхүү нийтлэг тулгамдсан асуудал тусгалаа олсон юм. ОҮИТБС-ыг боловсруулах, удирдахад төр засаг, иргэний нийгэм, компаниуд, хөрөнгө оруулагчид зэрэг бүхий л тал олон улсын санхүүгийн байгууллагуудын (ОУСБ) техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр шууд оролцож байгаагаараа уг санаачилга “дэлхийд анхдагч” болоод байна.

Төлснөө нийтэл (ТН буюу РWҮР) байгууллага бол байгалийн баялгийн орлогыг ил тод, хариуцлагатай удирдах явдлыг хөхиүлэн дэмжих чиглэлд ажиллаж байгаа дэлхийн 30 гаруй орны 300 гаруй гишүүн байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн дэлхий нийтийн хэмжээний иргэний нийгмийн эвсэл юм. Энэхүү тайланд тодорхой улс орнууд дахь ОҮИТБС-ын хэрэгжилтийн бодит байдалд хийсэн дүгнэлтүүдээс гадна цаашид ололт амжилтаа бататгахад юу хийвэл зохих тухай санал зөвлөмжүүдийг танилцуулж байна.

ОҮИТБС анх эхэлснээсээ хойших дөрвөн жилийн хугацаанд зарим мэдэгдэхүйц амжилтад хүрээд байна. Ази, Африк, Латин Америк, Төв Азийн нөөц баялаг ихтэй хорин нэгэн улсын засгийн газар уг санаачилгад нэгдэн орсон бөгөөд үүнд зайлшгүй шаардлагатай олон тооны заавар удирдамж, шалгуур үзүүлэлт, засаглалын бүтцийг Олон улсын зөвлөх бүлгээс (ОУЗБ) боловсруулан гаргаад байна. Гэсэн хэдий ч ТН эвслээс уг санаачилгын хэрэгжилтийн явцад хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд сайжруулах зүйл их байгаа нь харагдаж байна. Одоогоор нэгдэн ороод байгаа хорин нэгэн орноос:

- **Хоёр нь хөндлөнгийн бүрэн хяналт хийлгэж нэгтгэсэн ОҮИТБС-ын тайлангаа нийтлэн гаргаад байна.**
- **Найм нь ОҮИТБС-ын үйл явцыг удирдах хүнээ томилох анхны алхамаа ч хийж амжаагүй байна.**

- **Арав нь зохих ёсны олон талын оролцогч бүхий хороогоо хараахан байгуулаагүй байна.**
- **Арван нэг нь ажлын төлөвлөгөөний төслөө боловсруулаагүй, батлаагүй байна.**

Иймд олборлох үйлдвэрлэлийн санхүүгийн ил тод байдлыг сайжруулахад гаргасан ололт амжилтаа улам бататган гүнзгийрүүлэх, үүнийгээ орлогын хариуцлагатай байдал, ашиглалт дээшлэх нөхцөл болгон хувиргах үүднээс ТН эвслээс ОУИТБС-д оролцогч бүхий л талд хандан дараахь зүйлсийг уриалж байна:

1. **Хоосон гоё амлалтыг боломжийн цаг хугацааны хүрээнд хэрэгжих тодорхой үйл ажиллагаатай холбох нөхцлийг хангах замаар ОУИТБС-ын итгэл хүлээх чадварыг хамгаалах.**
2. **ОУИТБС-ын хэрэгжилтийг удирдан чиглүүлэх цаг завтай, албан ажлын дадлага туршлагатай, улс төрийн нөлөө бүхий удирдагчийг улс бүр томилон ажиллуулах.**
3. **ОУИТБС-ын нэг шаардлага бол иргэний нийгмийн жинхэнэ оролцоо мөн гэдгийг хүлээн зөвшөөрч тэднийг ОУИТБС-ын үйл явцын шийдвэрлэх алхам бүрт идэвхтэй оролцуулах явдлыг дэмжих.**
4. **Иргэний нийгмийн кампанит ажил явуулагч хэн бүхнийг ил тод байдлыг дэмжин сурталчилж ажилласных нь төлөө дарамт шахалт, айлган сүрдүүлэлтэд өртөхгүй байх баталгаагаар хангах.**
5. **Иргэний нийгмийн төлөөлөгчид зөвхөн энэ салбарын хүмүүс байж, улс төрийн нам, пүүс компаниуд зэрэг бусдын ашиг сонирхлыг төлөөлөхгүй байх нөхцлийг хангах.**
6. **ОУИТБС-д оролцож буй иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн санхүүгийн болон техникийн дэмжлэгийг нэмэгдүүлэх.**
7. **ОУИТБС-ын зардлуудыг санхүүжүүлэх хангалттай хөрөнгийг жилийн төсөвт хуваарилж, төлөвлөгдсөн үйл ажиллагаанд цаг хугацаанд нь дэмжлэг үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх.**
8. **ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй засгийн газруудад шаардлагатай техникийн дэмжлэг, тодорхой тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.**
9. **Компаниудын төлж буй төлбөр, засгийн газрын хүлээн авсан орлогын нэгтгэсэн тайланг компани болон орлого, төлбөрийн нэр төрлөөр нь задлан гаргах.**

10. ОҮИТБС-ын тасралтгүй байдал, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад туслах үүднээс түүнийг албан ёсны хуулинд суулгаж институцижүүлэх.
11. Засгийн газрын болон компаний санхүүгийн ил тод байдлыг дээшлүүлж, тогтмолжуулахад чиглэсэн бусад механизмтай ОҮИТБС-ын зорилго, арга хэлбэрийг уялдуулахад дэмжлэг үзүүлэх.
12. Орлогын ил тод, хариуцлагатай байдлыг бий болгоход чиглэсэн онцгой чухал нэг алхам гэдэг үүднээс гэрээний ил тод байдлыг дэмжих.
13. Ойрын жилүүдэд үндэсний дэд тайлан гаргах схемийг бий болгож нэвтрүүлэх.
14. ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч засгийн газрууд ил тод, хариуцлагатай зарлагын удирдлагыг сайжруулах механизм бий болгох явдлыг хөхиүлэн дэмжих.

ОРШИЛ

Газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн үйлдвэрлэлээс бий болгосон асар их орлогын ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах нь тэдгээр орлогыг ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг бий болгоход чиглүүлэн ашиглалтыг сайжруулахад амин чухал болохыг сүүлийн арван жилд улам бүр сайн мэддэг болоод байна. 2002 оны 9 дүгээр сард Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгыг (ОҮИТБС) эхлүүлэхэд энэхүү нийтлэг тулгамдсан асуудал тусгалаа олсон юм. ОҮИТБС-ыг боловсруулах, удирдахад төр засаг, иргэний нийгэм, компаниуд, хөрөнгө оруулагчид зэрэг бүхий л тал олон улсын санхүүгийн байгууллагуудын (ОУСБ-ууд) техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр шууд оролцож байгаагаараа уг санаачилга “дэлхийд анхдагч” болж байна.

Төлснөө нийтэл (ТН буюу РWҮР) байгууллага бол байгалийн баялгийн орлогыг ил тод, хариуцлагатай удирдах явдлыг хөхиүлэн дэмжих чиглэлд ажиллаж байгаа дэлхий нийтийн хэмжээний иргэний нийгмийн эвсэл юм. ТН байгууллага ОҮИТБС дахь иргэний нийгмийн оролцоог удирдан зохицуулахад тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн. Дэлхийн 30 гаруй орны 300 гаруй гишүүн байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн ТН эвсэл нь нөөц баялгаас хамааралтай орнуудад ажиллаж буй иргэний нийгмийн идэвхтнүүд, тэдний олон улсын холбоотнуудыг нэгтгэсэн асар том сүлжээ юм. Энэхүү тайланд ОҮИТБС-ын дэлхийн хэмжээний хэрэгжилтийн бодит байдалд хийсэн дүгнэлтүүдээс гадна цаашид ололт амжилтаа бататгахад юу хийвэл зохих тухай санал зөвлөмжүүдийг гаргахыг хичээсэн болно.

ОҮИТБС анх гарснаасаа хойших дөрвөн жилийн хугацаанд зарим мэдэгдэхүйц амжилт гаргаад байна. Ази, Африк, Латин Америк, Төв Азийн нөөц баялаг ихтэй хорин нэгэн улсын засгийн газар уг санаачилгад нэгдэн орсон бөгөөд олон орон хэрэгжилтийг эхлүүлэх тодорхой алхамууд хийгээд байна. ОҮИТБС-ын Олон улсын зөвлөх бүлэг (ОУЗБ) болон Нарийн бичгийн даргын газраас уг санаачилгыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай олон тооны заавар удирдамж, шалгуур үзүүлэлт, засаглалын бүтцийг боловсруулан гаргах ажил хийгдэж байна.

Энэхүү ахиц дэвшил нь оролцогч засгийн газрууд ба компаниудын зүгээс байгалийн баялгийн орлогын удирдлагыг улам ил тод болгох үүргийг олон нийтийн өмнө хүлээхэд бэлэн байгаагийн, үүнд иргэний нийгмийн байгууллагуудыг идэвхтэй оролцож байгаагийн, ОУЗБ идэвх зүтгэл гаргаж, хичээж ажилласны, мөн хандивлагч орнууд ба олон улсын санхүүгийн байгууллагуудын санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлж байгаагийн илрэл юм. Иймд энэхүү тайланд зарим нэг авууштай үлгэр жишээ, сургамжуудыг тодотгон харуулахыг оролдсон болно.

Гэсэн хэдий ч амьдрал дээрх практик туршлагаас үзэхэд, ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлэхэд төдийгүй нөөц баялаг ихтэй орнуудын сайн засаглал ба хөгжлийн гол түлхүүр болсон орлогын ил тод байдлаар бүрэн хангах туйлын зорилгодоо хүрэх чадварт ихээхэн саад тотгор учруулж буй хэд хэдэн асуудал байгаад ТН эвсэл анхаарлаа хандуулж байна. Эдгээр хүндрэл бэрхшээлүүдийн заримаас дурдвал, нэгдэн орсон хэд хэдэн засгийн газар иргэний нийгмийн байгууллагуудын голлох үүргийг хүлээн зөвшөөрч чадаагүй; иргэний нийгмийн идэвхтнүүдийг айлган сүрдүүлж, гадуурхсан; ОУИТБС-ыг хэрэгжүүлэх талаар авсан сайхан амлалт, тодорхой үйл ажиллагаа хоёрын хооронд ам, ажил зөрсөн; тухайн улсын түвшинд улс төрийн манлайлал сул, компаниудын оролцоо хангалтгүй байсан; хэрэгжүүлэгч засгийн газар, иргэний нийгмийнхэнд үзүүлэх техникийн болон санхүүгийн дэмжлэг хангалттай бус байсан; ил тод байдлын шаардлагуудыг санхүүгийн стандарт механизмтай нэгтгэн уялдуулахад ахиц дэвшил бага гарсан байна.

Энэхүү тайлан нь ТН эвслээс ОУИТБС-ын улс орны түвшний хэрэгжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээг танилцуулах зорилготой бөгөөд энэ үүднээсээ ОУИТБС-д хамтран хийсэн ажиглалтын үр дүн юм. Уг тайланг нийт нэгдэн орсон хорин нэгэн орны арван зургаад нь ажиллаж буй ТН эвслийнхэн болон иргэний нийгмийнхэнтэй хийсэн ярилцлагуудад тулгуурлав¹. Эндээс ОУИТБС-ыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, түүний эцсийн зорилгыг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн арван дөрвөн санал зөвлөмжийг тус эвслээс янз бүрийн оролцогч талуудад хандан гаргаж байна.

Энэхүү тайланд хөндөгдсөн асуудлуудыг авч үзэж, дор дурдсан санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар шинээр байгуулагдсан ОУИТБС-ын Удирдах зөвлөл, Нарийн бичгийн даргын газартай хамтран ажиллахыг ТН эвсэл нийт оролцогч талуудад уриалж байна. Эдгээр нь олборлох салбарын орлого дэлхийн эргэн тойронд буй нөөц баялаг ихтэй орнуудын нийт иргэдийн хөгжил цэцэглэлтийн эх үүсвэр болох нөхцлийг хангахад онцгой чухал алхамууд мөн гэдэгт бид итгэж байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖҮҮД

1: Хоосон гоё амлалтыг боломжийн цаг хугацааны хүрээнд хэрэгжих тодорхой үйл ажиллагаатай холбох нөхцлийг хангах замаар ОУИТБС-ын итгэл хүлээх чадварыг хамгаалах.

Нэгдэн орсон 21 улсын бараг тал хувьд нь засгийн газрууд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр авсан сайхан амлалтуудаа ямар нэг тодорхой үйл ажиллагаатай холбох тал дээр хойрго хандаж байна. Ийнхүү сайхан яриа, бодит ажил хоёрын зөрүүг арилгаж чадахгүй байгаа нь засгийн газрууд улс төр, эдийн засгийн бусад зорилгоо хангахад анхаараад ОУИТБС-д агуулагдсан ил тод байдлын зарчмын талаар хий хоосон ярихаас хэтрэхгүй байна гэсэн ойлголт төрүүлэхэд хүргэж байна. Хэрэв үүнийг анхаарч үзэхгүй бол, хэрэгжилтэд гарч буй энэхүү зөрүүтэй байдал нь ОУИТБС-ын итгэл хүлээх чадварыг болон иргэний нийгмийнхэний уг үйл явцад оролцох бэлэн байдлыг аажмаар алдагдуулж, улмаар уг санаачилга урт хугацаанд амжилттай хэрэгжих боломжийг бууруулсаар байх болно.

Нэгдэн орсон улс орон бүрийн хувьд ОУИТБС-ын гол чухал зарим алхмыг хангахад гаргасан ахиц дэвшлийг 2006 оны 8 дугаар сарын байдлаар гаргаж, Хүснэгт 1-д үзүүлэв.² ТН эвслийн гишүүдийн хийсэн энэхүү дүн шинжилгээнээс үзэхэд ОУИТБС-д нэгдэн орсон 21 улсаас:

- **Хоёр засгийн газар (Азербайжан, Нигери) ОУИТБС-ын гол чухал алхмуудын ихэнхийг хийгээд байгаа (олон оролцогч тал бүхий хороогоо байгуулсан, засгийн газраас үйл явцыг удирдан явуулах хүнээ гаргаж томилсон, үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний төслөө боловсруулсан, хөндлөнгийн хянагчаа томилсон) бөгөөд хөндлөнгийн хяналт бүрэн хийлгэж, нэгтгэсэн ОУИТБС-ын тайлангаа нийтлэн гаргаад байна.**

- **Найм нь ОУИТБС-ын үйл явцыг удирдах хүнээ томилох анхны алхамаа ч хийж амжаагүй байна.**
- **Арав нь олон оролцогч тал бүхий зохих хороогоо хараахан байгуулаагүй байна.**
- **Арван нэг нь хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө боловсруулаагүй, батлаагүй байна.**

Нэгдэн орох, хэрэгжилтэд ахиц дэвшил гаргах хоёрын хооронд ямар нэг хугацаа алдсан тохиолдолд үндэсний санаачилгын эрч хүч суларч, дотоодын иргэний нийгмийн идэвхтнүүдийн санаа зовних нэг эх сурвалж болдог. Камеруны ТН эвслийн нэгэн гишүүн ярихдаа: “Манай засгийн газар Их хэмжээний өртэй ядуу орны (ИХӨЯО буюу НРС) зэрэглэлд орохын тулд л ОУИТБС-ыг ашиглаж байгаа бөгөөд үнэндээ түүнийг хэрэгжүүлэх

бодолгүй байсан гэж үздэг” гэжээ. Монголын ТББ-ын өөр нэг төлөөлөгч хэлэхдээ: “Төр засагт ажиллаж буй олон хүн ОУИТБС-ын ач холбогдлыг олж хардаг. Гэхдээ яг хэрэгжүүлэх болохоор томоохон бэрхшээл үүсдэг. Хэрэгжүүлэх үйл явц маш удаан байна. Засгийн газрын хувьд энэ үйл явцыг өөр нэг таатай боломж буюу улс төрийн хувьд дэмжвэл зохих зүйл гэж үзэж байна” гэжээ.

“Āī ē áyððøyyéðýé ānóóāāē āī ē
 çāñāēēī āāçāð °°ð°° āāðūī ĸñyā
 çððñāī ī °ðð°° ðó ÷ ðēēðā;ē
 āāēāāāā ī ðøēī ī. Õyðyāē;ēyūð
 āæēūī ð°ē°āē°ā°° āyæ āāēðā;ē.
 Bī āð ī yā ā;ðyð, çī ðēī ī
 āāēāóēāāēð āāēðā;ēāyūñ āāāī ā yī y
 āæēūā ðyī óāēðāāæ āāēāāā ī ū ÷
 ðī āī ððī ēā;ē āāēī ā.”

Сиерра Леоне улсын Олборлолтын үндэсний нөлөөллийн эвсэл (ОУНЭ буюу NACE)-ийн гишүүн

Нэгдэн орсон улс орнуудын ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгөх арга зүйг ОУЗБ боловсруулан гаргаад байна. Энэ аргыг 2006 оны 10 дугаар сард болох Ослогийн бага хурлаар батлах юм. Энэхүү “баталгаажуулалт”-ын аргыг улс орнууд “нэгдэн орогч”-оос “нэр дэвшигч”, улмаар бүрэн “даган мөрдөгч” болж ахиц дэвшил

гаргасан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхөд ашиглана. Ийнхүү баталгаажуулах явцад ямар улсууд ахиц дэвшил хангалтгүй гаргаж байгаа нь харагдах юм.

Хоосон гоё амлалтаа боломжийн цаг хугацааны хүрээнд хэрэгжих тодорхой үйл ажиллагаатай холбох нөхцлийг хангах замаар ОУИТБС-ын итгэл хүлээх чадварыг хамгаалахыг ТН эвслээс бүх оролцогч талд уриалж байна. Ялангуяа:

- **Нэгдэн орсон засгийн газрууд ажлын төлөвлөгөөндөө ОУИТБС-ыг хэрэгжүүлэх гол гол алхмыг нэг бүрчлэн оруулсан байх, зохих ахиц дэвшил гарч байгааг баталгаажуулах арга ажиллагааг ашиглах нөхцлийг бүрдүүлэх ёстой.**

- **Нэгдэн орсон засгийн газрууд эдгээр ажлын төлөвлөгөөгөө цаг тухайд нь хэрэгжүүлэх улс төрийн хангалттай хүсэл зоригтой байх ёстой.**
- **ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс сайн ахиц дэвшил гаргаж буй орнуудыг сайшаан хүлээж авах, хангалтгүй ахиц дэвшил гаргаж байгаа улс орнуудыг "ОУИТБС-ын орнууд"-ын жагсаалтаас хасах замаар тус санаачилгын нэр хүндийг дээшлүүлж, хамгаалж байх ёстой.**

Хүснэгт 1: ОУИТБС-ын гол алхамуудаар гарсан ахиц дэвшил

Улс	Удирдагчаа томилсон	Олон оролцогч тал бүхий хороо байгуулсан	Ажлын төлөвлөгөө боловсруулж батласан	Хөндлөнгийн хяналт хийлгэж, нэгтгэсэн ОУИТБС-ын тайлангаа нийтлэн гаргасан
1. Азербайжан	Тийм	Тийм, гэхдээ байнгын бус	Тийм	Тийм
2. Болив				
3. Камерун	Тийм	Тийм	Тийм	
4. Чад				
5. Конго-Браззавилле	Тийм			
6. БН Ардчилсан Конго Улс	Тийм	Тийм		
7. Экваторын Гвиней				
8. Габон	Тийм			
9. Гана	Тийм	Тийм	Тийм	
10. Гвиней-Конакри	Тийм	Тийм	Тийм	
11. Казахстан	Тийм	Тийм	Тийм	
12. БН Киргиз Улс	Тийм	Тийм	Тийм	
13. Мавритани	Тийм	Тийм	Тийм	
14. Монгол	Тийм	Тийм	Тийм	
15. Непр				
16. Нигери	Тийм	Тийм	Тийм	Тийм
17. Перу	Тийм	Тийм	Тийм	
18. Сиерра Леоне				
19. Сан Томе Принсипе				
20. Зүүн Тимор				
21. Тринадад Тобаго				
Нийт нэгдэн орсон 21 орны дүн	13	11	10	2

Эх сурвалж: ОУИТБС-ын вэб сайт, дотоодын ТН эвслийн гишүүдтэй хийсэн ярилцлага

2: ОУИТБС-ын хэрэгжилтийг удирдан чиглүүлэх цаг завтай, албан ажлын дадлага туршлагатай, улс төрийн нөлөө бүхий удирдагчийг улс бүр томилон ажиллуулах

Өмнө нь нууцлан хадгалдаг байсан санхүүгийн мэдээлэлд гэрэл оруулах нь хэл амтай, амаргүй үйл явц байж болох талтай. Туршлагаас үзэхэд, уг үйл явцыг чадварлаг удирдагч тэргүүлэн явуулж гэмээнэ засгийн газрууд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх шинэчлэлд зайлшгүй шаардлагатай улс төр, санхүү, техникийн нөөцөө дайчлан гаргаж чаддаг байна.

"Oā í ú yō-eì òç÷í èé ñàéä ì ààí ú
Í ËÖÄÑ-úí çèé yāóúí óàèðāā÷-
āàèæ áí èí òí í ð āàéāā ðí .
Äyōāyú òyð áí è ì àø çāā ÷°è°°
ì óóòāé òçí. Ýí y í ú òççí èé óóāua
āçéóyòāyāyā í èí í āæèè ççðāèéí ò
í ú í yā áí èí ā÷ òyðyúð óā çéè
yāóāā í ðí èóí ðāçé ðí øèā āàéí à.
Óáí āàèòòāé yðò ì yāyèòyè, āāñ
òāā çāā āàðāāæ, ççðyā ðçèyúæ
àæèèèèòò òòñāāā òçí àèāā, yí y è
òí ì āñóóāāè áí èí í ā āàéí à."

Казахстаны ТН эвслийн гишүүн

Ерөнхийлөгчийн шийдвэрээр гүйцэтгэх эрх мэдлийг Шерифовт шилжүүлж, түүнд ОУИТБС-тай холбоотой шийдвэр гаргах боломж олгосон нь тус улсын засгийн газрын ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чадавхийг дээшлүүлсэн гэж ТН эвслийн гишүүд үзжээ. Эдгээр эерэг үлгэр жишээг зөвхөн магтаж сайшаагаад зогсохгүй даган дууриах шаардлагатай юм.

Ямар ч атугай үндэсний түвшинд удирдлага сул байх нь хэд хэдэн засгийн газрын ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлэх чадварт муугаар нөлөөлж байна. Казахстанд уг ажлыг удирдах хангалттай цаг зав, эрх мэдэлтэй удирдагч байхгүй байгаа нь уг санаачлагыг хэрэгжүүлэх хүчин чармайлтыг хойш тавихад хүргэж байна гэж эвслийн нэгэн гишүүн ярьж байлаа. Мавританий үндэсний хороо хөнгөн хуумгай зохион байгуулагдаж, хорооны гишүүд хуралдаа бэлтгэх хангалттай цаг хугацаа өгөхгүй байгаагийн

Нэгтгэсэн тайлангаа нэгэнт хэвлэн гаргаад байгаа Азербайжан, Нигери хоёр улсын засгийн газраас ОУИТБС-ыг удирдуулахаар томилсон ахлах албан тушаалын хүмүүсийг тус хоёр орны ТН эвслийн гишүүд уг ажлыг үр нөлөөтэй хийж чадах хүмүүс гэж үзсэн байна. Нигери дэх ОУИТБС-ын дарга Обиагели Эзекуэсили тус улсын Ерөнхийлөгч Олусегун Обасанжотой ажил төрлийн ойр дотно харилцаатай нь ОУИТБС-ын хэрэгжилтийн дотоод хөдөлгөх хүчийг бий болгоход шийдвэрлэх хүчин зүйл болдог хэмээн Нигерийн эвслийн гишүүд тодорхойлжээ. Мөн Азербайжаны Хэрэгжүүлэлтийн төрийн комиссийн тэргүүлэгч Самир Шерифов улс төрийн болон төрийн захиргааны талын саад тотгорыг даван туулахдаа чадварлаг гэж ТН эвслийн гишүүд үзсэн байна. Түүнчлэн

нэг шалтгаан бол тус санаачилгыг удирдагч нар өөр тэргүүлэх чиглэлийн ажил руу байнга татагдан орж байгаатай холбоотой гэдгийг эвслийн гишүүд цохон тэмдэглэсэн. Камеруны эвслийн нэгэн гишүүн ингэж ярьж байна: “ОУИТБС-ыг удирдахын хувьд гэвэл маш зав чөлөөгүй, их ажилтай улс төрчдөд энэ чухал үүрэг хариуцлагыг даалгадаг. Одоо бол, жишээ нь, сангийн сайд байгаа. ОУИТБС-ын хороонд мэдээлэл харилцаа дутагдаж байгааг ч үүгээр тайлбарлаж болох юм.”

ОУИТБС-ын үйл ажиллагааг удирдан жолоодох чадвартай албан тушаалтныг томилон ажиллуулахыг ТН эвслээс бүх нэгдэн орсон засгийн газруудад уриалж байна. Тэд ялангуяа:

- **Үр нөлөөтэй ажиллахын тулд цаг завтай, албан ажлын дадлага туршлагатай, улс төрийн нөлөөтэй байх ёстой.**
- **ОУИТБС-ын хэрэгжилтийн залгамж чанарыг хангах үүднээс тухайн албан тушаалд боломжийн урт хугацаанд байж, ажилтнуудын халаа солиог зохих ёсоор зохицуулдаг удирдагч байх ёстой.**

3: ОУИТБС-ын нэг шаардлага бол иргэний нийгмийн жинхэнэ оролцоо мөн гэдгийг хүлээн зөвшөөрч ОУИТБС-ын үйл явцын шийдвэрлэх алхам бүрт идэвхтэй оролцуулах явдлыг дэмжих

ОУИТБС-ын 5 дугаар шалгуурт “энэхүү үйл явцыг зохион байгуулах, түүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд иргэний нийгэм идэвхтэй оролцохын хамт олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмрээ оруулдаг байх”-ыг шаарддаг. Баталгаажуулах ажиллагааны тухай ОУЗБ-ийн хэлэлцүүлгийн явцад, аливаа улс иргэний нийгмийн хязгаарлагдмал оролцоотойгоор ОУИТБС-д “нэгдэн орж” болох боловч ажлын төлөвлөгөө, тайлангийн маягтууд боловсруулах, хөндлөнгийн хянагч нарыг сонгох гэх мэт шийдвэрлэх үе шатанд иргэний нийгмийн жинхэнэ оролцоог хангахгүйгээр “нэр дэвшигч” эсвэл “даган мөрдөгч” орон болж дэвшиж болохгүй гэдэгтэй санал нэг байсан³.

ОУИТБС-ын үйл явцад хувь нэмрээ оруулах жинхэнэ боломжийг иргэний нийгмийнхэнд олгож, улмаар хэрэгжилтийг илүү үр нөлөөтэй, нарийн чанд болгосон зарим жишээ байдаг. Жишээлбэл, Гана улсын олон оролцогч тал бүхий хороонд иргэний нийгмийн төлөөлөл болж орсон манай эвслийн нэгэн гишүүн түүнд тайлангийн маягтуудыг боловсруулахад оролцох

бодитой боломжийг олгож байсан тухай ярьж байв. Энэ гишүүний ярьж байгаагаар, иргэний нийгмийнхний зүгээс холбооны засгийн газраас эхлээд мужийн зөвлөл хүртэл бүх шатанд төлж буй төлбөрийг нийтлэх шахалт үзүүлсэн нь ОУИТБС-ыг орон нутгийн түвшинд хүртэл өргөжүүлэх анхны бөгөөд цорын ганц хүчин чармайлт болоод зогсохгүй тэд засгийн газрын тодорхой зарцуулалтуудын талаарх мэдээллийг нийтлэх шаардлага тавьсан байна. Эдгээр саналын аль алиныг нь Ганын тайлангийн маягтуудад тусган оруулсан гэж мэдэгдэж байгаа нь ОУИТБС-ын хэрэгжилтэд өндөр ач холбогдолтой үр дүн юм. Перуд албан бус ажлын хэсэгт орж ажиллаж байсан иргэний нийгмийн төлөөлөгч хэлэхдээ, уг ажлын хэсэгт байсан иргэний нийгмийн төлөөлөгчид ОУИТБС-ын тухай мэдээллийг түгээн дэлгэрүүлэх нарийн нягт стратеги гаргахад чиглэсэн лобби явуулсан бөгөөд эцэст нь энэ саналыг ажлын төлөвлөгөөнд оруулж чадсан байна.

Гэсэн хэдий ч, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх бодит алхамуудын үеэр иргэний нийгмийн гишүүд гадуурхагдах сэтгэгдэл төрсөн хэд хэдэн тохиолдол гарсан байна. Зарим оронд олон оролцогч тал бүхий хорооны хурлыг тогтмол хийдэггүй учраас иргэний нийгмийнхний оролцоо илүү хязгаарлагдмал байгаа юм шиг харагддаг байна. БН Киргиз Улсын ОУИТБС-ын олон оролцогч тал бүхий Зөвлөлдөх зөвлөлд гишүүнээр суудаг ТББ-уудын консорциумын гишүүний ярьснаар, зөвлөлийн хурал гурван сар тутамд нэг удаа болох ёстой боловч өнгөрсөн хоёр жилд тус зөвлөл дөнгөж хоёрхон хуралдсан байна. Нигерийн ТН эвслийн гишүүний хэлж байгаагаар, олон оролцогч тал бүхий хороо болох Үндэсний оролцогч талуудын ажлын хэсэг (YOTAX буюу NSWG) сүүлийн зургаан сарын турш огт хуралдахгүй байгаа нь ОУИТБС-ын үйл явцад иргэний нийгмийнхэн гадуурхагдаж байна гэсэн ойлголт төрүүлж байна.

“Eḏāyí eé í eéaí eéí ðyí àæùí
 ò°e°æ°a°o°í ä öóúí í yí ðyú
 í ḏóóéàḏ áí eí í æ í eäí í ä¿é. Çàñàeéí
 ààçḏúí ḏaí óá áàḏeí ò æe-æeéá
 ḏḏḏàè äyúḏ àá- í ḏæ eḏyúá ḏḏḏeùí
 ḏḏḏḏ ḏyḏ ḏàèàḏḏàà yḏùñáí ...
 Ḑḏḏeààñ °í í° óá áàḏeí ò æe-æeéá
 ḏḐüä-eèæ ḏàḏààààä¿é ó-ḏààñ
 eḏāyí eé í eéaí eéí ò°e°e°a°-eä
 ñaí àeàà áyèḏāyḏ ḏḏàḏḏà
 àæeààä¿é. Eéí yúñ eḏāyí eé
 í eéaí eéí óí eé ç¿äyúñ í yäyüeyéḏyè
 øeéááyḏ ààḏààñáí äyḏ yí àḏ ÷ ¿í äyñ
 àæeḏä¿é.”

Камеруны ТН эвслийн гишүүн

Бусад оронд хорооны хурлыг сүүлийн мөчид тулган зохион байгуулж, иргэний нийгмийн төлөөлөгчид, ялангуяа нийслэл хотоос гадна амьдардаг хүмүүсийг оролцох боломжгүй болгох явдал олон байгааг ТН эвслийн гишүүд мэдэгдэж байлаа. Хорооны хурлыг маш яаруу сандруу зохион байгуулснаас иргэний нийгмийн төлөөлөгчид оролцоход хүндрэлтэй байдаг гэж Камерун дах эвслийн нэгэн гишүүн ярьсан юм. Цаашилбал, иргэний нийгмийн төлөөлөгчид Камеруны ОУИТБС-ын Нарийн бичгийн даргын газрын ажилтнуудаас оролцож чадаагүй

хурлынхаа тэмдэглэлийг тарааж байхыг хүссэн боловч Нарийн бичгийн даргын газраас “Камеруны засаг захиргааны практикт ийм журам байхгүй” гэж хариулсан байна. Казахстанд хорооны хурлын зарыг голдуу урд орой нь хүргэдэг учраас орон нутгийн иргэний нийгмийн төлөөлөгчид нийслэл хот Астана руу очих боломжгүй болдог гэж эвслийн нэгэн гишүүн ярьсан байна.

Зарим оронд, хорооны хурлаар хэлэлцэж батлах байсан чухал баримт бичгүүдийг засгийн газрын ажилтнууд хурлаас өмнө тарааж чаддаггүй нь иргэний нийгмийн оролцоог хязгаарлаж байгаа гэх сэтгэгдэл төрүүлдэг байна. Ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах хурлын дундуур төлөвлөгөөний төслийг тараан танилцуулж байсан жишээ Камерун, Мавритани улсуудад гарсныг ТН эвслийн гишүүд мэдэгдэж байна. Үүнээс болж иргэний нийгмийн төлөөлөгчдийн хувьд уг санал болгосон баримт бичигт бодитой хувь нэмэр оруулах бэлтгэл муутай байсан байна.

Зориуд санаатай ч бай, зүгээр үр ашиг муутай хүнд суртлаас болсон ч бай, эдгээр туршлагаас үзэхэд, үнэндээ ОУИТБС-д оролцогч бусад тал иргэний нийгмийнхнийг тогтмол оролцуулах сонирхолгүй байна гэсэн ойлголт төрүүлж байгаа юм. Энэ талаар БН Киргиз Улсын ТН эвслийн гишүүн ийн ярьж байна: “Засгийн газар, зарим компаниуд, мөн зарим олон улсын мэргэжилтний зүгээс ТББ-ууд зөвхөн идэвхгүй үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн санаа цухалзуулдаг. Тэд зөвхөн бидэнд мэдээлэх ёстой гэж боддог, тэгээд л бол оо. Тэд асуудлыг бидэнтэй хамтарч ярилцах сонирхолгүй байдаг. Нэг удаа Дэлхийн Банкны төлөөлөгч хүртэл ОУИТБС бол иргэний нийгэмд зориулагдаагүй учраас иргэний нийгмийнхэн ингэж идэвхтэй оролцох ёсгүй гэж хэлж байсан.”

Иргэний нийгмийн жинхэнэ оролцоо бол ОУИТБС-ын нэг гол шаардлага гэж үзэхийг ТН эвслээс нийт оролцогч талуудад уриалж байна. Засгийн газрууд, ОУСБ-ууд ОУИТБС-ын шийдвэрлэх үе шат бүрт иргэний нийгэм идэвхтэй оролцох явдлыг дэмжиж байх ёстой. Нэн ялангуяа, эдгээр оролцогч талууд дараахь арга хэмжээг авч ажиллавал ОУИТБС-ын хэрэгжилтийг улам бататгах юм:

- **Бүр анх ОУИТБС-д татан оролцуулж эхлэх үеэсээ л иргэний нийгмийн оролцоог дэмжих механизмыг анхаарч авч үзэх.**
- **ОУИТБС-ыг удирдах үндэсний бүтцийн тухай шийдвэр гаргах, ажлын төлөвлөгөө боловсруулах, тайлангийн маягт боловсруулах, хөндлөнгийн хянагчийг сонгох, тэдний олж илрүүлсэн зүйлд дүн шинжилгээ хийх зэрэг ОУИТБС-ын амин чухал шат бүрт иргэний нийгмийг идэвхтэй оролцуулах явдлыг дэмжих.**
- **Олон оролцогч тал бүхий хорооны бүрэлдэхүүнд иргэний нийгмийн болон бусад оролцогч талын тэнцвэрт харьцааг тогтоох.**

- Олон оролцогч тал бүхий хорооны гишүүд, түүний дотор иргэний нийгмийн төлөөлөгчдөд ирэх хурлын талаар эртнээс мэдэгдэн, хурлын материалыг урьдчилж тараах, ингэснээр хорооны гишүүд хурлаас өмнө үзэж танилцах хангалттай хугацаа өгөх.
- Олон оролцогч тал бүхий хорооны хурлын тэмдэглэлийг хорооны бүх гишүүнд тарааж хүргэх.

4: Иргэний нийгмийн кампанит ажил явуулагч хэн бүхнийг ил тод байдлыг дэмжин сурталчилж ажилласных нь төлөө дарамт шахалт, айлган сүрдүүлэлтэд өртөхгүй байх баталгаагаар хангах

Ил тод байдлыг дэмжин сурталж буй иргэний нийгмийн идэвхтнүүдийг нухчин дарж буй засгийн газрууд хүний үндсэн эрхийг зөрчөөд зогсохгүй ОУИТБС-ын гол зорилт, шалгуур, зарчмуудыг утга учиргүй болгож байгаа юм. Хэдийгээр ОУИТБС-д нэгдэн орсон зарим засгийн газар иргэдийн иргэний болон улс төрийн эрхийг ерөнхийдөө хүндэлдэг боловч бусад засгийн газар байгалийн баялгийн орлогын ил тод, хариуцлагатай удирдлагыг хөхиүлэн дэмжих ажилд идэвхтэй оролцсон иргэний нийгмийнхнийг айлган сүрдүүлж байна.

Үүний нэг ноцтой жишээ бол Конго-Браззавиллегийн ТН эвслийн хоёр зохицуулагч болох Кристиан Моунзео, Брайс Макоссо нарыг тус улсын засгийн газар баривчлан хорьж, ял тулгасан явдал юм. Моунзео, Макоссо нарыг шүүх хурал бол ардчилал хэврэг тогтсон төрийн дэглэмд авилгын эсрэг тэмцэлд оролцсон иргэний нийгмийн идэвхтнүүдийг нухчин дарахад бэлэн, тийм чадавхитай байдгийн нэг жишээ боллоо. Үнэн хэрэгтээ, энэ хоёр хүнийг баривчлах үед Пойнте-Нойре прокурорын хийсэн мэдэгдэл, цагдаагийн ажилтнуудын авсан байцаалтын мөн чанар, компаний үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг хураан авсан байдал зэргээс үзэхэд (оноосон ял зэм нь бус) энэ шүүх ажиллагаа бол Конго-Браззавиллегийн газрын тосны баялгийг илүү хариуцлагатай удирдахыг уриалсан тэдгээр хүмүүсийн амыг барих гэсэн улс төрийн сэдэлтэй оролдлого байж болохоор байна.⁴

Гэтэл, ганцаар ноёрхсон дэглэмтэй ч гэсэн засгийн газар нь ОУИТБС-д нэгдэн орсон орнуудад иргэний нийгмийнхний нөхцөл байдал хамаагүй дор байна. Жишээлбэл, Экваторын Гвиней улсын Ерөнхийлөгч Теодоро Обианг Нгуемагийн засгийн газар 2005 онд ОУИТБС-д нэгдэн орсон. Гэвч бодит байдал дээр тус дэглэм үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө гэх мэт иргэний ба

улс төрийн үндсэн эрхийг системтэйгээр хязгаарлаж байна гэж засгийн газар төдийгүй төрийн бус байгууллагууд үе үе шүүмжилдэг нь энд авилга, ил тод байдал гэх мэт асуудлаар иргэний нийгмийнхэн ямар нэг идэвхтэй ажиллагаа явуулах орон зай бараг байхгүй байгааг харуулж байна.⁵

Ил тод байдлыг дэмжин сурталчлах ажил явуулсных нь төлөө иргэний нийгмийн кампанит ажил явуулагчдад дарамт шахалт үзүүлэхгүй буюу айлган сүрдүүлэхгүй байх нөхцлөөр хангахыг ТН эвслээс нийт оролцогч талуудад уриалж байна. Ялангуяа ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд дараахь зүйлс шаардагдана:

- **Нэгдэн орсон засгийн газрууд нийт иргэдийнхээ, түүний дотор иргэний нийгмийн кампанит ажил явуулагчдын эрхийг хамгаалах.**
- **Нэгдэн орсон засгийн газруудын дарамт шахалтын тухай мэдүүлсэн хэргийг ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс шалгах.**
- **Ил тод байдлын кампанит ажил явуулагчдын хүний эрхэд аюул занал учирсан тохиолдолд түүнийг хамгаалахын төлөө ОУИТБС-ын нийт оролцогч талууд дипломат болон бусад боломжит бүх арга хэрэгсэлийг ашигладаг байх.**

Мөн Конгийн засгийн газар Кристиан Моунзео, Брайс Макоссо нарт оноосон ял зэмээ нэн даруй зогсоохыг ТН эвсэл шаардаж байна.

Б: Иргэний нийгмийн төлөөлөгчид зөвхөн энэ салбарын хүмүүс байж, улс төрийн нам, пүүс компаниуд зэрэг бусдын ашиг сонирхлыг төлөөлөхгүй байх нөхцлийг хангах

Иргэний нийгмийг “гуравдагч салбар” хэмээн тодорхойлж ирсэн уламжлалтай нь улсын хэвшлийн буюу улс төрийн оролцогчид эсвэл хувийн хэвшлийн компаниудыг төлөөлөх үүрэгтэй оролцогчдоос тэднийг ялгаж өгсөн хэрэг юм. Иргэний нийгмийн байгууллагуудын жишээнд: ард иргэдэд тулгуурласан буюу анхан шатны байгууллагууд, үндэсний ТББ-ууд, олон улсын ТББ-ууд, хэвлэл мэдээллийн холбоод, үйлдвэрчний эвлэлүүд, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүд, шашины байгууллагууд, бүртгэлтэй буяны байгууллагууд орно. ТББ-уудын энэхүү үүрэг, хараат бус байдал нь бусад хоёр хэвшлийн оролцогчдыг олон нийтийн эрх ашигт нөлөөлснийх нь төлөө хариуцлага хүлээлгэх боломж олгодог. ОУИТБС дахь иргэний нийгмийн хууль ёсны, үр нөлөөтэй оролцоог тогтвортой хадгалахын тулд иргэний нийгмийн

төлөөлөгчид компаний болон засгийн газрын ашиг сонирхол, нөлөөнөөс хараат бус байх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай.

ОУИТБС-ын хэрэгжилтийн явцад иргэний нийгмийн төлөөлөгчид хараат бус байдлаа хадгалж чадсан зарим нэг сайхан жишээ байдаг. ОУИТБС-ын үйл явцын эерэг талуудын нэг бол иргэний нийгмийнхэн олон талт хороонд орж ажиллах гишүүдээ засгийн газрын хөндлөнгийн оролцоогүйгээр сонгосон явдал байлаа гэж Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ) дахь эвслийн гишүүд ярьсан юм. Азербайжанд хэдийгээр байнгын олон оролцогч тал бүхий хороо байхгүй боловч хөндлөнгийн хяналтыг сонгодог хороонд оруулах төлөөлөгчдөө иргэний нийгмийнхэн өөрсдөө сонгодог байна. Үүний нэг адил, Гана улс ОУИТБС-д нэгдэн орсны дараа засгийн газрын албан тушаалтнуудаас үндэсний иргэний нийгмийн толгойн байгууллагад хандаж, 10 хүний бүрэлдэхүүнтэй үндэсний удирдах хороонд орох нэг төлөөлөгчөө нэр дэвшүүлэхийг ТББ-уудаас хүссэн байна.

Харин олон оролцогч тал бүхий хороонд оруулах төлөөлөгчдөө өөрсдөө сонгох боломж олгоогүй учраас ОУИТБС дахь иргэний нийгмийн хараат бус байдал, оролцоо муудсан талаар хэд хэдэн орны эвслийн гишүүд мэдэгдсэн байна. Казахстан, Камерун, Мавритани, Монгол зэрэг улсад олон оролцогч тал бүхий хороонд оруулах иргэний нийгмийн төлөөлөгчдийг сонгохдоо засгийн газар эхнээс нь нөлөөлсөн эсвэл гардан сонгосон гэж эвслийн гишүүд ярьжээ.⁶

"I ayūfī ēē ī dī ēōī ā- Ǿāēōōāūī
ç°āē°ēā ī dī ō ēdāyī ēē ī ēēāī ēēf
Ǿ°ē°ē°ā-āēēf çādēī ūā yd÷ēī
ōç÷f ēē nāēā °°d°° nī ī āī æ āānāī
ī ū ēēō āāēāāā... D°ē°ē°ā-āēēā
ī yd āyāøççēæ, nī ī āī ō yī ād ī yā
ōyāyō, ēē Ǿī ā ādāā çāī āāēāāāçé.
Nī ī āī āānī ī āçēāççāēēf çādēī ī ū
ī ÷ÈDÁÑ-ūī Ǿāēāādō ī ēēāī ēō
ī ōōǾāē. Ōyā ōā ānōōāēūā ī yā
ēō nī ī ēdōī ōāçé āāēāāā ī yō
nāī āāāāāā ā°ā°ā ī ēī ī ōōdāēā ēdæ
ī dī ēōāī āāçé. Yī y ī ū ōā çēē yāōūā
āāāāçé ōāāāōdōōēæ āāēf ā."

Казахстаны ТН эвслийн гишүүн

Перуд иргэний нийгмийг ОУИТБС-ын үйл явцад татан оруулж байгаа арга хэлбэрт санаа зовж байгаагаа эвслийн нэгэн гишүүн илэрхийлсэн юм. 2006 оны 5 дугаар сараас өмнө засгийн газраас ОУИТБС-ын олон оролцогч тал бүхий албан бус ажлын хэсэг байгуулаад байсан нь албан ёсны олон оролцогч тал бүхий хороо биш бөгөөд түүндээ иргэний нийгмийн төлөөллийг оруулсан байв. Харин уг эвслийн гишүүний ярьснаар, "Иргэний нийгмийг төлөөлж оролцох цөөн гишүүнийг үндсэндээ Дэлхийн Банк гардан сонгож авсан. Хэдийгээр хүн бүр нийтлэг нэг зорилго, үзэл баримтлалыг хуваалцаж байгаа боловч энэ бүлгийг Дэлхийн Банкнаас тохоон томилж байгаа мэт сэтгэгдэл төрсөн" гэжээ. Перугийн засгийн газар энэ асуудлыг шийдвэрлэнэ гэж үзсэний үндсэн дээр нэгэн алхам хийсэн нь 2006 оны 5 дугаар сард ОУИТБС-ын ажлын

төлөвлөгөөг батлаж, олон оролцогч тал бүхий хороо байгуулах дээд захирамж гаргасан явдал юм. Энэ захирамжийн дагуу иргэний нийгмийн байгууллагууд тус хороонд өөрсдийн төлөөлөгчдөө сонгон оруулах боломжтой болох юм.

Нигери гэх мэт ОУИТБС-ын үйл ажиллагааны гол алхамуудыг хэрэгжүүлэхэд бодитой ахиц дэвшил гаргасан оронд хүртэл ҮОТАХ-т орох иргэний нийгмийн төлөөлөгчдийг сонгоход засгийн газар хөндлөнгөөс оролцож байсан нь иргэний нийгмийн хараат бус байдал, ОУИТБС-ын оролцооны чанарт анхнаас нь саад тотгор учруулсан хэрэг байв. Нигерийн ТН эвслийн нэгэн гишүүн ярьж байгаагаар, 2004 онд Ерөнхийлөгч Обасанжо уг 28 гишүүнтэй ҮОТАХ-т оруулахаар иргэний нийгмийн гурван төлөөлөгчийг урьсан байна. ТН эвслийн энэ гишүүний ярьсанчлан, “ҮОТАХ-т орох иргэний нийгмийн төлөөлөгчдийг ерөнхийлөгч сонгож авснаас болж иргэний нийгмийн оролцоонд сэв суусан. Мөн ҮОТАХ-т байгаа иргэний нийгмийн төлөөлөгчид иргэний нийгмийн өргөн хүрээнд эргэж тайлагнах механизм байхгүй байв. Энэ нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд хэд хэдэн бэрхшээлтэй асуудал үүсгэсэн юм. Ажлын төлөвлөгөө, тайлангийн маягуудыг боловсруулахдаа иргэний нийгмийнхэнтэй зохих ёсоор зөвлөлдөөгүй” гэсэн байна. Иргэний нийгмийн энэхүү оролцоог өргөтгөх үүднээс 2005 оны 6 дугаар сард өөр нэгэн бүлэг болох Иргэний нийгмийн удирдах хороо байгуулагдсан бөгөөд иргэний нийгмийн өргөн хүрээтэй эвслээс сонгогдсон 10 төлөөлөгчөөс бүрдсэн байв. 2006 оны 2 дугаар сард ҮОТАХ ба иргэний нийгмийн удирдах хорооны төлөөлөгчид харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан нь ОУИТБС-ын үйл явц дахь иргэний нийгмийн оролцооны цар хүрээг өргөтгөх үйл явцыг институцижүүлнэ гэдэгт эвслийн гишүүд найдаж байна.

Олон оролцогч тал бүхий хороонд оруулах иргэний нийгмийн төлөөлөгчдийг засгийн газраас сонгохыг зөвшөөрснөөс үүдсэн нэг бэрхшээл бол тэд иргэний нийгмийн тухай ойлголтыг өргөтгөж, салбарын холбоод, улс төрийн намууд, парламентыг төлөөлсөн бусад оролцогчдыг хорооны бүрэлдэхүүнд оруулах нь олонтаа байдаг явдал юм. Монгол дахь эвслийн гишүүний ярьж байгаагаар, иргэний нийгмийн төлөөлөгчдийг сонгоход засгийн газар үүрэг гүйцэтгэсэн нь компаний ашиг сонирхлыг төлөөлсөн хүмүүсийг сонгоход хүргэсэн байна. Мавританид 2006 оны 1 дүгээр сард байгуулагдсан олон оролцогч тал бүхий байгууллага болох Үндэсний хороонд засгийн газраас иргэний нийгмийн

"Èðàуг èé í èéàì èéí òòòàé àèàí èé í èáí èòíí ð è èàà í àíí àèéí í àí àé Ñí àуní èé ç°àé°èà èðàуг èé í èéàì ууñ ààðàèòàè àèøççí ààéòàçé. Í àíí èðàуг èé í èéàì èéí ò°è°è°à-èà àуæ ççууà ààéààà òçí ççñ ì ààí ù çí уí òуòуàòуу ñàèààòóí òí èáí í àиí ò°è°è°à-èà ààéààà. Ўí у è àуòòууèòуé àñòòàè àí èí í à àèéí à."

Монголын ТББ-ын төлөөлөгч

төлөөлөгчдийг оруулахдаа улс төрийн намын гишүүдийг сонгож байсан талаар эвслийн гишүүд ярьж байсан. Камеруны ТН эвслийн гишүүдийн ярьж байгаагаар, засгийн газар олон оролцогч тал бүхий хороонд орох иргэний нийгмийн төлөөлөгчдийг анх сонгохдоо иргэний нийгмийн төлөөлөгчдийн дотор парламентын гишүүдийг оруулсан байжээ.

Иргэний нийгмийн төлөөлөгчид жинхэнэ ёсоор энэ салбараас сонгогдох нөхцлийг хангахыг ТН эвсэл нийт оролцогч талуудад уриалж байна. Тэд ялангуяа:

- **Иргэний нийгэм олон оролцогч тал бүхий хороонд оруулах төлөөлөгчдөө өөрсдөө сонгох боломж олгох,**
- **Иргэний нийгмийн төлөөлөлд салбарын холбоод, улс төрийн намын төлөөлөгчид, парламентын гишүүдийг оруулж, энэ тухай ойлголтыг өргөтгөхөөс зайлсхийх.**

6: ОУИТБС-д оролцож буй иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн санхүүгийн болон техникийн дэмжлэгийг нэмэгдүүлэх

Иргэний нийгмийн чадавхи хязгаарлагдмал байх (санхүүгийн нөөц, техникийн мэдлэг туршлагын аль алины хувьд) нь ОУИТБС-ын амжилтад хүндрэл учруулдаг. Яагаад гэвэл, хэдийчинээ ил тод байхын хэрээр орлогын удирдлагыг төдийчинээ сайжруулдаг гол механизмуудын нэг бол засгийн газраас дотоодын иргэний нийгмийн өмнө (өргөн олон нийтийн төлөөлөгчид гэдэг үүднээс) хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх явдал юм. Иргэний нийгэм төр засагтай ижил түвшний ойлголттой байх ёстой. Мэдлэг, дадлага туршлага бий болгож, санхүүгийн эдгээр асуудалд итгэдэг болгоход урт удаан хугацаа шаардагддаг. Иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх асуудлыг хойш тавих нь хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн ОУИТБС-ын зорилгыг бүхэлд нь дордуулж болох юм.

Иргэний нийгмийн байгууллагууд өөрсдийн хүссэн утга учиртай арга хэлбэрээр ОУИТБС-д оролцоход хангалттай техник мэдлэг туршлага дутагдаж байгааг энэхүү тайланд ярилцлага өгсөн эвслийн гишүүн бүр илэрхийлж байв. Камерун дахь ТН эвслийн нэгэн гишүүний хэлсэнчлэн: “Иргэний нийгмийнхний чадавхийг илүү их бэхжүүлэх ёстой, ингэснээр иргэний нийгмийн гишүүд хөндлөнгийн хяналт, тайлан нэгтгэх ажиллагаа зэрэг ОУИТБС-ын техник арга хэрэгслүүдийг илүү сайн ойлгодог болох болно.”

Техникийн дэмжлэг туслалцаа авах шаардлагаас гадна иргэний нийгмийн байгууллагууд ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцоход

"Èðàÿí èé í èéàÿì ä òèèààð- áóé
òàì àèéí òíì òçí àðÿé àÿðòøÿÿé
áí è ì ÿäèÿä +ààààð äòòààààð,
Í -ÈÒÁÑ-ur òàèèàí àààñ ààðñàí
òííí ì ÿàÿÿéççäèèà çàèèàí
øèí æèÿò +ààààð äòòààààð ÿààèè
àèèààà. Òòñ ÿàñèèéí ç°àò°í ò°°í
òííí ì òçí ççñ è èéí ì ÿäèÿä
òòðòèèààòòàè ààéí à. Ààçðóí
òííí ì èíí í àí èòá, çàñàèéí
ààçàðòòàè òèèÿí íèí í íðí èòí à-
òàèòòààí òòðèí çàÿð èðàÿí èé
í èèàí èéí òí èé +ààààòè äòòààààò
ÿàààè íèí í òàà òí òèí èààí à à°à°à
çàðèí í ÿä òàðí èèèéí +àí àðòàè
ÿðèà òÿèÿèòççèÿàò ààèè òÿàø
íðí èòí à-ííð íðí ò àÿèòàÿè ì òòòàè
àèèààà."

Азербайжаны ТН эвслийн гишүүн

боловсруулсан боловч санхүүгийн дэмжлэггүйн улмаас хэрэгжүүлж чадахгүй байгаагаа ярьсан байна.

Иргэний нийгэмд үзүүлэх дэмжлэг нь дотоодын бүлэглэлүүдэд шууд олгосон эсвэл эдгээр хөрөнгийг дотоодод үр нөлөөтэй хуваарилж чадах олон улсын ТББ-аар дамжсан, ямар ч байсан үндэсний засгийн газрын байгууллагуудаас хараат бус байх ёстой. Их Британий Олон улсын хөгжлийн департамент саяханаас иргэний нийгэмд зориулсан санхүүжилтээ засгийн газраар дамжуулан олгох шаардлага тавьсан нь тус байгууллагаас ОУИТБС-д оролцогч иргэний нийгмийн бүлгүүдийг дэмжих чадварт муугаар нөлөөлсөн байна. Харин иргэний нийгмийн бүлгүүдийн зүгээс энэ нь биднийг хараат бус байх ойлголтдоо буулт хийхэд хүргэж байна гэж үзэн татгалзсан байна.

Хэрэгжүүлэгч орнууд дахь иргэний нийгмийн бүлгүүдэд үзүүлэх санхүүгийн болон техникийн дэмжлэг туслалцаагаа шууд нэмэгдүүлэхийг ТН эвслээс ОУИТБС-ын оролцогч талуудад уриалж байна. Нэн ялангуяа:

- **Иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх, тэдэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх явдлыг засгийн газар зэрэг бусад салбарт үзүүлэх дэмжлэгтэй нэг зэрэг төлөвлөж, төсөвлөж, хэрэгжүүлэх**

шаардлагатай хөрөнгө санхүүгээ олж авахад бэрхшээл учрах нь олонтаа. Хөрөнгө санхүү дутагдалтайгаас болж орон нутаг дахь эвслийн гишүүд нийслэл Киншаса, Астана хотуудад очиж, ОУИТБС-тай холбоотой хуралд оролцоход бэрхшээлтэй байдаг гэж БНАКУ, Казахстан дахь эвслийн гишүүд онцлон тэмдэглэж байв. БНАКУ-ын нэгэн гишүүний ярьж байгаагаар: “Хөрөнгө санхүүгийн нөөц дутагдах нь иргэний нийгмийн бүлгүүд үр ашигтай ажиллахад саад болдог нэг томоохон асуудал юм. БНАКУ-ын зүүн хэсгийн Лумбубашид амьдардаг эвслийн гишүүд ихэнх хурал болдог Киншаса хотод ирж очиход хүндрэлтэй байдаг. Үүнээс болж тухайн орон нутгийнхаа асуудлуудыг маш сайн мэддэг, газар дээр нь амьдарч байгаа гишүүд маань хурлаа тасалж, ОУИТБС-тай холбоотой асуудлуудыг сайтар ярилцаж чаддаггүй.” Гана дахь эвслийн нэг гишүүн, түүний байгууллага хэвлэл мэдээлэл болон уурхайн орчимд ажиллаж амьдарч буй ард иргэдэд зориулж ОУИТБС-ын талаар сурталчлах стратегийн төлөвлөгөө

ёстой. Үүнийг үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган оруулвал зохино.

- **Хандивлагчид болон ОУСБ-ууд хэрэгжүүлэгч засгийн газруудад үзүүлж буй дэмжлэгийнхээ нэг адилаар иргэний нийгмийн оролцогчдод нэг бол ОУИТБС-ын Итгэлцэлийн санд хандив өргөх замаар эсвэл хоёр талын зээл тусламжийн хөтөлбөрүүдээр дамжуулан дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Гэнэтийн болон бага хэмжээний эрэлт хэрэгцээнд зориулан арга хэмжээ авахын тулд уян хатан байх шаардлага нь нэн ялангуяа орон нутгийн иргэний нийгмийнхэнд үзүүлэх дэмжлэгийн салшгүй хэсэг байх ёстой.**
- **Түүнчлэн компаниудын зүгээс зохих техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж байх шаардлагатай.**
- **Мөн ОУИТБС-ын Нарийн бичгийн даргын газар нь иргэний нийгэмд үзүүлэх техникийн болон санхүүгийн дэмжлэгийг удирдан зохицуулахад хангалттай боловсон хүчний болон бусад нөөцтэй байх ёстой.**

7: ОУИТБС-ын зардлуудыг санхүүжүүлэх хангалттай хөрөнгийг жилийн төсөвт хуваарилж, төлөвлөгдсөн үйл ажиллагаанд цаг хугацаанд нь дэмжлэг үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх

ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд зориулсан хөрөнгө санхүүг тусгайлан төлөвлөх нь ОУИТБС-ын үйл ажиллагааг зохисгүй хугацаа алдалт, тодорхойгүй байдал гаргахгүйгээр явуулах нөхцлийг хангах, мөн нэгдэн орсон засгийн газрууд ба компаниуд хүлээсэн амлалт үүргээ биелүүлж байгаагаа харуулахад онцгой ач холбогдолтой.

Санхүүжилтийг тухайн үед нь түр зохицуулдгаас болж ОУИТБС-ын хэрэгжилтэд хугацаа алдсан гэж хэд хэдэн орны эвслийн гишүүд мэдэгджээ. Азербайжанд 2004 оны 11 дүгээр сард гарын үсэг зурсан харилцан ойлголцлын санамж бичигт хөндлөнгийн хяналт гэх мэт ОУИТБС-ын үйл ажиллагаанд зориулсан санхүүжилтийн тусгай зохицуулалт байхгүйгээс гадна жил бүрийн улсын төсөвт ОУИТБС-ын зардлыг оруулаагүй байна гэж ТББ-уудын эвслийн гишүүд мэдэгджээ. Санхүүжилтийн зохицуулалтын будлиантай, тодорхойгүй байдал нь ОУИТБС-ын хэрэгжилтэд гарах ахиц дэвшлээс хойш татаж байна гэж тэд үзсэн байна.

“Өөрийн ажиллагаагаа өргөсгөх нь төсвийн зардалд
нэгдсэн хөрөнгийн хөрөнгө мөнгө гаргах хүсэл зориг дутагдалтай байж болно.
Энэ төлөөлөгчийн ярьсанчлан, “Өөр нэг бэрхшээл бол засгийн газар ямар ч мөнгө
гаргахгүй байгаа явдал юм. Засгийн газар мөнгө гаргахгүй байгаа учраас л
Дэлхийн Банк төлөхөд хүрсэн. Энэ нь улс төрийн хүсэл зориг дутагдаж байгааг
харуулж байна.”

Азербайжаны ТББ-ын эвслийн гишүүн

эвслийн гишүүний хувьд, манай засгийн газарт ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд зориулж хөрөнгө мөнгө гаргах хүсэл зориг дутагдалтай байна гэжээ. Энэ төлөөлөгчийн ярьсанчлан, “Өөр нэг бэрхшээл бол засгийн газар ямар ч мөнгө гаргахгүй байгаа явдал юм. Засгийн газар мөнгө гаргахгүй байгаа учраас л Дэлхийн Банк төлөхөд хүрсэн. Энэ нь улс төрийн хүсэл зориг дутагдаж байгааг харуулж байна.”

ОУИТБС-ын зардлыг санхүүжүүлэх хөрөнгийг жилийн төсөвт тусгайлан оруулж, тэдгээрийг цагт нь хуваарилах нөхцлийг хангахыг ТН эсвлээс оролцогч талуудад уриалж байна. Ялангуяа, энэ нь дараахь агуулгатай байж болно:

- **Тодорхой бөгөөд хангалттай хэмжээний төсвийг ажлын төлөвлөгөөтэй хамт боловсруулан гаргах.**
- **Холбогдох хөрөнгийг санхүүгийн жилийн эхэнд гаргах буюу ОУИТБС-ын ажлын хэсгийн мэдэлд шилжүүлэх, эсвэл ядаж төлөвлөгдсөн үйл ажиллагааны өмнө өгдөг байх.**

Мөн Гана дахь эвслийн нэгэн гишүүн, засгийн газар ОУИТБС-ын зардлыг жилийн төсөвтөө оруулаагүй учраас ОУИТБС-ын хэрэгжилт хойшилсон гэжээ. ОУИТБС-ыг дэмжихийн тулд санхүүгийн зардлуудыг нь даах ёстой гэдэг утгаар нь авч үзвэл засгийн газар маань дэмжих бэлтгэлгүй байна гэсэн үг, ийнхүү хөрөнгө гаргах дургүй байгаа нь ОУИТБС-ын өмнө шууд хүлээсэн үүргээ хөсөрдүүлж байгаа хэрэг гэж Монголын нэгэн ТББ-ын төлөөлөгч үзсэн байна. Энэ төлөөлөгчийн ярьж байгаагаар, “Үүнийг нэгэнт Дэлхийн Банк санхүүжүүлж байгаа цагт тэд энэ талаар огт санаа зовохгүй. Харин засгийн газар үүнд мөнгө гаргах шаардлагатай болоход дэмжих эсэхийг нь мэдэхгүй” гэжээ. Перугийн ТББ-уудын

8: ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй засгийн газруудад шаардлагатай техникийн дэмжлэг, тодорхой тохиолдолд санхүүгийн дэмжлэг хангалттай үзүүлэх

Барууны зарим засгийн газар ба ОУСБ-ууд ОУИТБС-ын үйл ажиллагааг эхлүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгаа боловч тус санаачилгын үндэсний хэмжээний хэрэгжилтийг амжилттай явуулахад туслах олон зүйлийг цаашид хийх шаардлагатай байна. Хандивлагч засгийн газрууд ба олон улсын санхүүгийн байгууллагуудын зүгээс илүү өргөн хүрээтэй дадлага туршлага олгох сургалт явуулах, тодорхой “хүндрэлтэй” тохиолдолд хэрэгжүүлэгч засгийн газруудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар ОУИТБС-ын хэрэгжилтэд цаашид дэмжлэг үзүүлж болох юм. ОУИТБС-д нэгдэн орсон олон засгийн газар засаглалын сул эсвэл бүр дампуурсан бүтэцтэйгээсээ болж зовж зүдэрч байгаа учраас эдгээр улсад уг санаачилгыг хэрэгжүүлэхэд туслахад олон улсын үр нөлөөтэй дэмжлэг зайлшгүй шаардлагатай.

Санхүүгийн туслалцааг Дэлхийн Банкнаас удирддаг Олон Хандивлагчийн Итгэлцэлийн Санд⁷ хандив өргөх замаар эсвэл хоёр талын зээл тусламжийн хөтөлбөрөөр дамжуулан үзүүлж болох юм. Сүүлчийн арга нь Дэлхийн Банкны журмын дагуух санхүүжилтийн механизмыг бодвол харьцангуй шуурхай, илүү уян хатан байдлаар хэрэгжүүлж болдгоороо онцгой ач холбогдолтой байдаг.

Хандивлагч засгийн газрууд болон ОУСБ-ууд техникийн болон санхүүгийн туслалцаа үзүүлэх замаар хэрэгжүүлэгч засгийн газруудын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлсээр ирсэн. ОУИТБС-ын албан ёсны вэб сайтаас үзэхэд, Норвеги, Их Британи, Нидерланд, Герман улсуудын засгийн газар Олон Хандивлагчийн Итгэлцэлийн Санд хандив өргөж, цаашид ч хувь нэмрээ оруулахаа амлаад байгаа бөгөөд хамгийн том хандивлагч нь Их Британи улс болоод байна. Түүнчлэн, Норвегийн засгийн газраас Хөгжлийн төлөө газрын тос хэмээх хөтөлбөрийг бий болгосон нь ил тод байдлыг дээшлүүлж, сайн засаглалтай болохыг эрмэлзэж байгаа байгалийн баялгийн орлогоос хамааралтай хөгжиж буй орнуудын засгийн газарт техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байна. Эцэст нь, ОУЗБ-ээс

“Çànaëéí ààçàð í èí í ñàí àà-èèààà ààðùí ÷íüà çòðæ ààéààà ÷ ÷÷÷í èéàýú òýðüæ÷÷éýò àèèèòàí , òàòí èèèéí àí èí í ñàí ò÷÷àèéí í°ò àòòààààè ààéààà í ù ì ýäýààýæ ààéí à. Ýí ý í ù àýðòøýýèòýé àñòòààè àí èí í à ààéí à àýæ ÷çýæ ààéí à. Äýèòèéí Ààí èí ù í ýà àí è ÷÷ðýà àí è òýðüæ÷÷éýèòèéí à÷òýò, ì àòàí èçì òòàüà àèè àí èàí òí à òòèèàò ýàààè àýæ àè àí ààí à, àýòýè í àí í àí í ò èéí òí òèí èàí è ààðààà÷ è ààéí à.”

**Сиерра Леонегийн Олборлолтын
Үндэсний Нөлөөллийн Эвслийн
(ОУНЭ) гишүүн**

2005-2006 оны хугацаанд хийсэн цуврал хурлуудынхаа үеэр ОУИТБС-ын Нарийн бичгийн даргын газрыг хэрэгжүүлэгч орнуудад үзүүлэх санхүүгийн болон техникийн туслалцааг зохицуулахад туслах хангалттай боловсон хүчний болон санхүүгийн нөөцтэйгээр байгуулахыг дэмжсэн билээ

Эдгээр нааштай үр дүнг эс тооцвол, засгийн газарт техникийн мэдлэг чадвар, заримдаа санхүүгийн нөөц дутагдах явдал ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд саад болсоор байна гэж хэд хэдэн орны ТН эвслийн гишүүд үзсэн байна. Энэхүү гарын авлагад үзүүлсэн Сиерра Леонед тулгарч буй хүндрэлтэй асуудлуудаас гадна Мавританий засгийн газарт чадавхи дутагдсанаас болж Дэлхийн Банкны төлөөлөгчийн газрыг ОУИТБС-ын хэрэгжилтийн Нарийн бичгийн даргын газраар давхар ажиллах хүсэлт гаргасан талаар эвслийн гишүүн ярьсан байна. Энэхүү эвслийн гишүүний ярьсанчлан, “ОУИТБС-д тулгарч буй хамгийн том бэрхшээлийн нэг бол засгийн газрын чадавхи дутагдах явдал юм. Бид энэ үйл ажиллагаанд оролцож буй бүх хүнд зориулж зориуд сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эс тэгвээс, уг ажлыг засгийн газрын албан тушаалтнууд ойлгож оролцохгүй, зөвхөн Дэлхийн Банкаас үзүүлж буй шахалт болж хувирах юм.” БНАКУ дахь ОУИТБС-ын олон оролцогч тал бүхий хорооны хуралд оролцож буй засгийн газрын албан тушаалтнуудын ОУИТБС-ын үзэл баримтлалын тухай ойлголт хоцрогдож байгааг болон энэ нь хорооны хурлыг үр бүтээл муутай болгож байна гэж үзэж байгаагаа эвслийн нэгэн гишүүн ярьж байлаа.

ТН эвслийн гишүүдийн илэрхийлж байгаа үзэл бодол саяхан ОУИТБС-ын Нарийн бичгийн даргын газраас уул уурхайн салбар дахь ОУИТБС-ын хэрэгжилтийн талаар гаргасан тайлангийн дүгнэлттэй яв цав таарч байна. Энэхүү тайланд дурдсанчлан, “Улс орны дотоод дахь ОУИТБС-ын хэрэгжилтийн үйл явцыг үр нөлөөтэй болгоё гэвэл илүү тууштай дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна. Энэ талаар үндэсний ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцож буй бүх хүлээн авагч засгийн газрууд, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн төлөөлөгчид нэгэн зэрэг давтан ярьж байв.”⁸

Нэгдэн орсон засгийн газруудад илүү их техникийн дэмжлэг туслалцаа, зарим тохиолдолд санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг ТН эвслээс уриалж байна. Ялангуяа:

- **Хандивлагчид болон ОУСБ-ууд нэг бол ОУИТБС-ын Итгэлцэлийн Санд хандив өргөх замаар эсвэл хоёр талын зээл тусламжийн хөтөлбөрөөр дамжуулан техникийн болон зарим тохиолдолд санхүүгийн туслалцаа үзүүлэх хэрэгтэй байна. Хоёр дахь арга зам нь гэнэтийн болон бага хэмжээний эрэлт хэрэгцээг хангах тал дээр илүү уян хатан байх ёстой.**
- **Компаниуд болон иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс ч зохистой үед техникийн болон санхүүгийн туслалцаа үзүүлэх ёстой.**

- ОУИТБС-ын Нарийн бичгийн даргын газрыг хэрэгжүүлэгч орнуудад үзүүлэх санхүүгийн болон техникийн туслалцааг зохицуулахад туслах хангалттай боловсон хүчний болон санхүүгийн нөөцтэйгээр байгуулахыг ОУИТБС-ын бүх оролцогч талууд дэмжих ёстой.

9: Компаниудын төлж буй төлбөр, засгийн газрын хүлээн авсан орлогын нэгтгэсэн тайланг компани болон орлого, төлбөрийн нэр төрлөөр нь задлан гаргах

Өмнө нь олборлох үйлдвэрлэлийн санхүүгийн урсгалууд олон нийтийн хяналтаас далд нууц байсан газруудад компаниудын төлж буй нийт төлбөрийн дүнг засгийн газрын хүлээн авсан нийт орлогын дүнтэй харьцуулан нэгтгэж нийтэлдэг болсон нь нэг чухал алхам юм. Гэвч, энэ байдлаар “нийт дүнгээр нэгтгэх” нь иргэд, иргэний нийгэм, компаниуд төдийгүй засгийн газруудын хувьд хэд хэдэн хүндрэл бэрхшээл үүсгэдэг. Компани тус бүрийн үндэсний эдийн засагт оруулж буй хувь нэмрийг иргэд мэдэх эрхтэй төдийгүй аль компани ямар хэмжээний орлого оруулж байгааг мэдэхгүйгээр иргэний нийгмийнхний зүгээс чухам хаана орлогын урсгал алдагдаж байгааг тодорхой тогтоох, уг асуудлыг багасгах алхамууд хэрэгжүүлэх боломжгүй юм. Түүнчлэн тоон мэдээллийг нэгтгэн гаргах нь нэг компаний тааруухан гүйцэтгэл бусад компаний нэр хүндийг доошлуулах боломжтой болгодог. Эцэст нь, хэдийгээр

засгийн газар ба иргэдийн хооронд итгэлцэл бий болгох нь улс төрийн тогтвортой байдалд амин чухал боловч нийт дүнг нэг бүрийн төлсөн дүн, хүлээж авсан орлоготой харьцуулж харж чадахгүй байх нь уг үйл явцад итгэх олон нийтийн итгэлийг төрүүлэхгүй.

“Задлан гаргах” арга нь хамаагүй ашиг тустай бөгөөд орлого, төлбөрүүдийг илүү дэлгэрэнгүй, өөрөөр хэлбэл тодорхой компани болон орлогын урсгалтай холбоотой орлого, төлбөр бүрээр задлан харуулдаг. Ийм задаргаа бүхий тоон мэдээлэл нийтлэх нь төлсөн төлбөрийг хүлээн авсан орлоготой нь харьцуулж, эдгээр орлогын урсгалын талаар засгийн

“Í yá áçð-ëüí çàäèàñàí òííí
 ì yáüëüë í èèòüèè áàéààà í ü
 Í èààðèéí èðäüí èé í èéàí èéí
 yáñèèéí í yá àí è í èí èò àì æèèò ðì .
 Òàðòòüí Áðòííí èéí ò°í àé°í àèéí
 òüí àèòòüí òàééàí à òónàààñàñàí
 í yá áçð-èèñüí çàààðààà í ü àèü
 àæ àðòéí í yáæ üí àð òüí æüüí èé
 ò°éà°ð çàñàèéí ààçàðò ò°èæ
 áàéàààà í èéàí òí à ãñàð èò òón
 ä°ò°í àí èñí í .”

Нигерийн ТН эвслийн гишүүн

газрууд ба компаниудыг хариуцлага хүлээдэг болгохуйц хэмжээний олборлолтын орлогын тухай мэдээллээр дотоодын оролцогчдыг хангаж өгдөг.

Хөндлөнгийн хяналт хийлгэж, нэгтгэсэн тайлангаа бодитойгоор нийтлэн гаргаад байгаа хоёр улсаас Нигери улс нь тоон мэдээллээ задлан гаргасан байна. 2006 оны 4 дүгээр сард нэгтгэсэн тайланд тоон мэдээллийг задлан гаргаж, нийтэлсэн явдал нь төлбөр ба орлогод дүн шинжилгээ хийж, далд байсан зөрүүг ил гарган авч үзэх чадварт маань маш чухал байсан гэж Нигерийн ТН эвслийн гишүүд үзсэн байна. Түүнчлэн Гана улс дээрх мэдээллээ компани, ашигт малтмал, орлогын урсгал бүрээр задлан гаргахыг зорьж байгаа тухайгаа мэдэгдээд байна.

Нөгөө талаас, Азербайжан улс дөрвөн удаагийн нэгтгэсэн тайландаа тоон мэдээллийг компани бүрээр задалж гаргаагүй байв. Азербайжаны ТН эвслийн гишүүдийн үзэж байгаагаар тоон мэдээллийн задаргаа байхгүй байгаа нь хоорондын зөрөөнд дүн шинжилгээ, сайжруулалт хийх чадварт хүндрэл учруулж байгаа ажээ. Энэ талаар Азербайжан дахь ТН эвслийн нэгэн гишүүн ийнхүү ярьсан юм: “Азербайжанд үйл ажиллагаа явуулж буй газрын тосны компани бүр бүтээгдэхүүн хуваах гэрээний (БХГ) дагуу ажилладаг учраас мэдээллийг нэг бүрчлэн гаргасан бол компани бүрийн төлсөн төлбөрийг БХГ-ний дагуу хүлээсэн үүрэгтэй нь харьцуулж дүн шинжилгээ хийх боломжтой байх байлаа. Төрөөс гаргаж өгсөн тоо баримт ба газрын тосны компаниудын гаргасан нэгдсэн дүн хоёрын хооронд зөрүү гарах үед нэг бүрчилсэн мэдээлэл байхгүй учраас ийнхүү зөрж байгаа шалтгааныг задлан шинжилж, судлах боломжгүй болгож байна.”

Төлбөрийн мэдээллийг компаниар болон орлогын урсгалаар нь задалж гаргах нь тэдний арилжааны өрсөлдөх чадварт хохирол учруулна гэж санаа зовж байгаагаар зарим компани мэдэгдээд байна. Гэвч, Нигерид 2006 оны 4 дүгээр сард гаргасан нэгдсэн тайланд тоон мэдээллийг компани бүрээр задлан танилцуулсан нь тухайн компаний арилжааны нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлсэн талаар тус тайланд хамрагдсан Шелл, Экссон, Чеврон зэрэг компаний нэг нь ч гомдол гаргаагүй юм. Норвегийн газрын тосны хоёр компани болох Статойл, Нордск-Хидро компаниуд үйл ажиллагаа явуулсан улс орон бүрийнхээ засгийн газарт төлж буй материаллаг төлбөрийнхөө ихэнхийг жилийн тайландаа оруулж нийтлэн гаргаагаар төлөвлөж байгаагаар саяхан мэдэгдсэн.⁹ Канадын Талисман компани засгийн газруудад төлсөн нөөц ашиглалтын төлбөрөө жилийн тайландаа аль хэдийн оруулж нийтлээд байна. Шелл компаний хувьд, ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй орнуудад компани бүрийн төлбөрийг илээр тайлагнах ёстой хэдий ч, энэ нь эцсийн эцэст хүлээн авагч засгийн газрын шийдэх асуудал гэж үзэж байна.¹⁰

Тоон мэдээллийг компани бүрээр болон орлого, төлбөрийн төрөл бүрээр задлан нийтлэх явдлыг дэмжихийг ТН эвслээс нийт оролцогч талуудад, нэн ялангуяа хэрэгжүүлэгч засгийн газар, компаниудад хандан уриалж байна.

10: ОУИТБС-ын тасралтгүй байдал, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад туслах үүднээс түүнийг албан ёсны хуулинд суулгаж институцижүүлэх.

Олон оронд, тэр ч байтугай ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд бодитой ахиц дэвшил гаргаад байгаа орнуудад хүртэл тухайн засгийн газар уг санаачилгыг цаашид дэмжсэн хэвээр байх эсэх нь тодорхойгүй байгаа нь улс төрийн дэглэм өөрчлөгдөж болзошгүйтэй шууд холбоотой. Харин тус санаачилгад зүгээр нэг гүйцэтгэх тогтоолоор эрх олгохоосоо илүүтэй албан ёсны хуулинд суулгаж өгвөл ОУИТБС-ыг засгийн газраас тасралтгүй дэмжих магадлал дээшлэх юм.

Í Í ÒÈÁÑ-úí Òòòàé òòòèèéí
Ò°ñèèéá ááòèáí ááòááò yááé í àø
÷òòàè. Øèí ý çáñáèéí ááçàð Í ÒÈÁÑ-
úá ¿ðáýèæ¿¿èýí òýðýáæ¿¿èýòá¿é
áýæ øèéáýæ áí èí ò ó÷ðááñ ýí ý
í ù óá ¿èè ýáð ¿ðáýèæýí ý áýááèéá
ááòáèéáááæòòèáð í ýá áðáá ðí .
Ì °í ýí ýí í ù òòòèù òí áðííò
ááéáòòèéáááá òòòèù ðí í ù òð
í èáí æ ááéááááááðáá í àø ÷òòàè à÷
òí èáí ááí èòí é.

Нигерийн ТН эвслийн гишүүн

алхам юм. Мөн Гана улсад ОУИТБС-ыг институцижүүлэх хуулийн төслийг гүйцэтгэх засаглалаас боловсруулж парламентад өргөн барих талаар иргэний нийгмийнхний гаргасан саналыг засгийн газар хүлээж авсан тухай эвслийн нэгэн гишүүн ярьсан юм.

ОУИТБС-д нэгдэн орсон ихэнх оронд зөвхөн засгийн газар гүйцэтгэх тогтоолоороо дамжуулж ОУИТБС-ыг хэрэгжүүлэх эрх олгоод байна. Жишээлбэл, Мавритани улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үндэсний хороо байгуулах тухай захирамжид тус улсын Ерөнхий сайд 2006 оны 1 дүгээр сарын 12-нд гарын үсэг зурсан байна.¹² 2006 оны 5 дугаар сард Перугийн гүйцэтгэх засаглалаас ОУИТБС-ыг хэрэгжүүлэх бүрэн эрх албан ёсоор олгож, ОУИТБС-ын ажлын төлөвлөгөө гарган, олон оролцогч тал бүхий хороог байгуулах тухай дээд

Цөөн хэдэн оронд ОУИТБС-ыг албан ёсны хуулинд суулгаж институцижүүлэх хүчин чармайлт гаргаад байна. Жишээлбэл, Нигери улсад Нигерийн Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын (НОУИТБС) тухай хуулийн төслийг гүйцэтгэх засаглалынхан боловсруулаад байгаа бөгөөд одоо уг төсөл хууль тогтоох байгууллагаар хэлэлцэгдэж байна. Хэрвээ энэ хуулийн төсөл батлагдвал хууль ёсны институциуд байгуулагдаж, НОУИТБС-ын чиг үүргийг хуульчлах юм.¹¹ Удахгүй болох 2007 оны ерөнхийлөгчийн болон хууль тогтоох байгууллагын сонгуулиар төрөх шинэ ерөнхийлөгч ОУИТБС-ыг үүнтэй ижил түвшинд дэмжихгүй байж болзошгүй учраас энэ нь Нигери улсын хувьд онцгой чухал

захирамж гаргасан гэж эвслийн нэгэн гишүүн мэдээлжээ. Иймэрхүү тохиолдолд энэхүү хүлээсэн үүргийг заавал биелүүлэх хууль тогтоомж болгон тусгаснаар цаашид хэрэгжих тасралтгүй чанарыг нь улам дээшлүүлэх боломжтой.

ОУИТБС-ыг албан ёсны хуулинд суулгаж институцижүүлэхийг ТН эвслийн зүгээс нэгдэн орсон засгийн газруудад уриалж байна.

11: Засгийн газрын болон компаний санхүүгийн ил тод байдлыг дээшлүүлж, тогтмолжуулахад чиглэсэн бусад механизмтай ОУИТБС-ын зорилго, арга хэлбэрийг уялдуулахад дэмжлэг үзүүлэх

Нөөц баялгаас хамааралтай орнуудын засгийн газрууд ОУИТБС-д оролцох эсэх нь сайн дурын шинжтэй бөгөөд улс төрийн хүсэл зоригоос хамаардаг. Одоогийн байдлаар, компаниудын тайлагнах эсэх нь эдгээр нөөц баялгаас хамааралтай орны засгийн газрууд хошуучлахаас хамаарч байгаа бөгөөд зөвхөн ингэж шаардаж байгаа улс орнуудад л тухайн үед нь хэрэгжиж байна.

ОУЗБ-ийн хэлэлцүүлгийн явцад ил тод байдлыг илүү системтэй, тогтвортойгоор хангах шаардлагыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр ОУИТБС-ын зорилго, арга хэлбэрийг засгийн газрын болон компаний тайлагнадаг бусад механизмтай нэгтгэн уялдуулах ёстой гэсэн санал зөвлөмж гаргахад хүрсэн юм. Эдгээр механизмын заримаас дурдвал: ОУСБ-ын зээл олгоход тавигдах шаардлагууд, экспортын зээлийн баталгаа гаргах шаардлагууд, нягтлан бодох бүртгэлийн стандартууд, үнэт цаасны зах зээлийн бүртгэлд тавигдах шаардлагууд байна. Эдгээр механизм бол анхаарлаа хандуулвал зохих хамгийн чухал чиглэлүүдийн нэг гэж ТН эвслийн гишүүд үзэж байна.

Зарим ОУСБ-ууд аль хэдийн үүрэг амлалт авч, ил тод байдлын шаардлагуудтай системтэй уялдуулах тал дээр ахиц дэвшил гаргаад байна. Жишээлбэл, Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК), Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ) хоёр хоёулаа олборлох үйлдвэрлэлийн төслүүдэд зээл олгох шаардлагууддаа ил тод тайлагнах заалтуудыг оруулаад байна. Эдгээр нь нөөц баялаг ихтэй орнуудын засгийн газар болон олборлолтын компаниудад аль алинд нь адилхан үйлчлэх юм.¹³

Хөрөнгийн зах зээлүүдийн хувьд, Лондонгийн Хөрөнгийн Биржийн Альтернатив Хөрөнгө Оруулалтын Зах Зээл (АХОЗЗ буюу AIM) газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудыг жагсаалтанд оруулах шаардлагадаа төлж буй төлбөрөө улс орон бүрээр гаргах заалт оруулаад байна. АХОЗЗ-ийн

зааварт “өргөдөл гаргагчийн зүгээс болон түүний нэрийн өмнөөс хөрөнгө олж авах эсвэл ашиглахтай холбоотойгоор аливаа засгийн газар, зохицуулах эрх бүхий байгууллага эсвэл түүнтэй төстэй этгээдэд төлж буй 10,000 фунт стерлингээс дээш дүнтэй аливаа төлбөрийг” компани илээр тайлагнах ёстой гэжээ.

Олон улсын санхүүгийн тайлагнах стандартууд (ОУСТС буюу IFRS) ба Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн стандартууд (НХЗНББС буюу GAAP) хоёрыг нэгтгэн уялдуулах алхамууд хийгдэж байгаа нь эдгээр тайлагнах шаардлагыг ил тод байдлыг сайжруулах зарчмуудтай хослуулах таатай боломжийг олгож байна. Эдгээрээс гол анхаарах асуудал бол ОУНББС14 (Үйл ажиллагааны сегментүүд) ба одоогоор хэлэлцэгдэж байгаа олборлох үйлдвэрлэлтэй тусгайлан холбоотой стандартууд юм.

Нэгтгэсэн тайлан гаргах шатандаа бодитойгоор хүрээд байгаа улс орнууд дахь ТН эвслийн гишүүдийн ярьж байгаагаар, өнөөг хүртэл хуримтлагдсан туршлагаас үзэхэд эдгээр төрлийн механизм нь ОУИТБС дахь компаниудын нягт нямбай, цагтаа оролцох оролцоог хангахад зайлшгүй чухал шаардлагатай байж болох юм. Газрын тосны жижиг компаниуд тайлангаа хугацаанд нь ирүүлэлгүй удааснаас хүлээж авах эцсийн хугацааг зөрчиж, хөндлөнгийн хяналтын тайлан хойшлогдоход хүрч байна гэж Азербайжан дах эвслийн гишүүн ярьж байлаа. Компаниудыг мэдээллээ үнэн зөвөөр, цаг хугацаанд нь ирүүлэхийг шаардсан механизм байх нь энэхүү бэрхшээлийг арилгахад тустай гэж уг төлөөлөгч үзсэн байна. Үүний нэг адилаар, Нигерийн засгийн газраас шууд заавар өгч, ямар нэгэн нууцлалын заалтыг үл хэрэгсэхээ тодорхой зарлан мэдэгдсээр байтал зарим компани тайлан нэгтгэн гаргаж буй газарт мэдээллээ ирүүлэхдээ туйлын хойрго удаан хандаж байсан байна.

Төлбөрөө заавал улс орон бүрээр гаргаж тайлагнах механизм бэхжиж, өнөөг хүртэл ОУИТБС-ын гаргасан нааштай ахиц дэвшлийг бататгахын зэрэгцээ олборлох үйлдвэрлэлийн салбар дахь орлогын ил тод байдлын асуудлыг үндэсний болон олон улсын норм, стандартад бүрэн нэгтгэн оруулна гэдэгт ТН эвсэл итгэлтэй байна.

Засгийн газрын болон компаний санхүүгийн ил тод байдлыг дээшлүүлж, тогтворжуулах бусад механизмтай ОУИТБС-ын зорилго, арга хэлбэрийг уялдуулахыг дэмжихийг ТН эвслээс нийт оролцогчдод уриалж байна. Нэн ялангуяа, хүлээн авагч засгийн газрууд, компаниуд, ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс ил тод байдлын шаардлагыг дараахь стандартуудад нэгтгэн оруулах шаардлагатай:

- **Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартууд**
- **Үнэт цаасны зах зээлийн бүртгэлийн шаардлагууд**
- **Экспортын зээлийн баталгаа олгох шаардлагууд**
- **ОУСБ-ын зээл олгох шаардлагууд**

12: Орлогын ил тод, хариуцлагатай байдлыг бий болгоход чиглэсэн онцгой чухал нэг алхам гэдэг үүднээс гэрээний ил тод байдлыг дэмжих

Гадаадын компаниуд болон хүлээн авагч засгийн газруудын хоорондын хөрөнгө оруулалтын гэрээг ил тод болгохгүйгээр улс орныхоо байгалийн баялгийг худалдаж байгаа эсэхийг эсвэл анх гэрээнд заасан нөхцлийн дагуу төлбөрөө төлж байгаа эсэхийг иргэд мэдэх боломжгүй билээ. Ийм гэрээнүүдэд өртөг зардлыг хэрхэн тодорхойлж, олсон ашгийг компани, хүлээн авагч засгийн газар хоёр хэрхэн хуваахыг заасан нөхцөл болзол, томъёонууд орсон байдаг. Засгийн газар болон компаниудыг хариуцлагатай байлгахын тулд тухайн компани ба хүлээн авагч засгийн газрын хооронд байгуулсан гэрээний нөхцлүүдийг олон нийт мэдэж байх шаардлагатай.

Засгийн газар ба компаниудын зүгээс ийнхүү гэрээний нөхцлүүдийг ил болгох нь арилжааны болон өрсөлдөөний давуу талыг алдагдуулна гэж маргах нь олонтаа боловч ОУВС-гийн Нөөц баялгийн орлогын ил тод байдлын тухай зааварт энэ талаар дурдахдаа: “Тэвч практик дээр гэрээнд гарын үсэг зурснаас хойш нэг их удалгүй тухайн гэрээний нөхцлүүдийн талаар уг салбарынхан хэдийнэ мэдчихсэн байдаг талтай. Ийм учраас гэрээг нийтэлснээр стратегийн давуу тал алдаад байх зүйл бага” гэсэн байдаг.¹⁴ Түүнчлэн, төлбөртэйгээр гэрээг танилцуулдаг арилжааны үйлчилгээ ч байх нь олонтаа.

Гэрээний ил тод байдал амин чухал ач холбогдолтойд ТН эвслийн гишүүд санал нэгтэй байдаг. БН Киргиз Улс, БНАКУ-аас асуултад хариулагчдын үзэж байгаагаар, олон тооны хөрөнгө оруулалтын болон хөнгөлөлтийн гэрээг тойрсон нууцлал нь ОУИТБС-ын үйл явцыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болгодог байна.

Гэрээний ил тод байдал нь маргаан үүсэхээс сэргийлэхэд тустай байж болохын нэг жишээ бол саяхан Чад улсын засгийн газар ба газрын тосны Чеврон, Петронас компаниудын хооронд гарсан маргаан юм. 2006 оны 8 дугаар сард Чадын Ерөнхийлөгч Идрисс Дебай төлөх ёстой татвараа дутуу төлсөн гэдэг үндэслэлээр Чеврон, Петронас компаниудыг тус улсаас хөөсөн бөгөөд үүнийг нь дээрх хоёр компани хоёулаа үгүйсгэж байгаа юм. Хэрвээ тухайн компаниуд ба засгийн газрын хооронд байгуулсан арилжааны гэрээнийхээ зарим үндсэн нөхцлүүдийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тавьдаг, мөн компаниуд өөрсдөө төлсөн төлбөрөө бие даан нийтэлдэг байсан бол ингэж сэжиглэгдэх үндэслэл хамаагүй бага байх сан билээ.¹⁵

Орлогын ил тод, хариуцлагатай байдлыг бий болгох нэг чухал алхам гэдэг үүднээс гэрээний ил тод байдлыг дэмжихийг ТН эвслээс нийт оролцогчдод уриалж байна. Ялангуяа:

- **ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс гэрээний ил тод байдлын асуудлыг ОУИТБС-д оруулах талаар тодорхой санал зөвлөмжүүд гаргах ёстой.**

13: Ойрын жилүүдэд үндэсний дэд тайлан гаргах схемийг бий болгож нэвтрүүлэх

Байгалийн баялаг ихтэй олон оронд холбооны түвшинд цуглуулсан орлогынхоо зарим хэсгийг бүс нутаг, муж, орон нутгийн засгийн газруудад хуульд заасан томъёоллын дагуу шилжүүлж байдаг. ОУИТБС-ын үндэснийхээс доогуур түвшний хэрэгжилтийн талаар саяхан гаргасан нэгэн тайланд, байгалийн баялгаас орлого олдог 56 хөгжиж байгаа орны 17 нь байгалийн баялгийн орлогыг үндэсний засгийн газраас орон нутгийн засгийн газарт шилжүүлэхэд зориулсан албан ёсны хууль тогтоомж эсвэл тодорхой бодлогын хүрээтэй байна гэжээ.¹⁶ Зарим оронд компаниуд шууд орон нутгийн засгийн газарт төлбөр төлж байна. Уг тайланд орон нутгийн түвшинд орлогыг зохисгүй удирдсанаас болж авилга, ядуурал, зөрчил мөргөлдөөн үүсгэж байгаа хэд хэдэн механизмыг олж тогтоосны дотор албан тушаалтны ивээлд тулгуурлан засгийн газар хооронд орлогын шилжүүлэг хийх, орон нутгийн түвшинд санхүүгийн данс бүртгэлээ тайлагнах эрх зүйн хүрээ дутагдах явдал орж байна.¹⁷

Орлогын ил тод байдлын талаар тавьж буй аливаа өргөн хүрээтэй хүчин чармайлтад ч бас орон нутгийн засгийн газруудад шилжүүлсэн эдгээр төлбөрийг олон нийтэд ил тод болгох шаардлага орж байна. ОУЗБ энэхүү арга хэмжээний ач холбогдлыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр ОУИТБС-ын зүгээс үндэснийхээс доогуур түвшний хэрэгжилтийн асуудлаар цаашид ажиллахыг зөвлөмж болгоод байна.¹⁸

ОУИТБС-д нэгдэн орсон зарим оронд орлогыг үндэснийхээс доогуур түвшинд тайлагнах асуудлыг оролцогч талууд аль хэдийн авч үзэж эхлээд байна. ТН эвслийн нэгэн гишүүний ярьснаар, Гана улсын үндэсний уул уурхайн орлогын 5 орчим хувь нь орон нутгийн засгийн газрын бүтэц болох тойргийн хурлуудад шууд шилждэг байна. Эдгээр орлогыг шилжүүлэхийн ач холбогдлыг танин мэдсэн иргэний нийгмийн байгууллагууд холбооны засгийн газраас тойргийн хурлуудад шилжүүлж байгаа төлбөрүүдийг нийтлүүлэх кампанит ажил амжилттай явуулсан нь ОУИТБС-ыг үндэснийхээс доогуур түвшинд өргөжүүлэн хэрэгжүүлэхэд чиглэсэн анхны хүчин чармайлт болсон юм. Нигери улсад НОУИТБС-аас тусдаа санаачилга гарч, үүний үр дүнд засгийн газар үндэсний түвшнээс мужийн засгийн газруудад шилжүүлж буй орлогуудаа нийтэлж эхэлсэн байна.

ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс үндэснийхээс доогуур түвшний санхүүгийн ил тод байдлын талаар тусгайлан санал зөвлөмжүүд гаргаж, тэдгээрийг аль болох эртнээс хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг ТН эвслийн зүгээс нийт оролцогчдод уриалж байна.

14: ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч засгийн газрууд ил тод, хариуцлагатай зарлагын удирдлагыг сайжруулах механизм бий болгох явдлыг хөхиүлэн дэмжих

Хэдийгээр ОУИТБС-ын гол чиглэл бол байгалийн баялгаас засгийн газарт орж буй орлогыг нийтэд ил болгох явдал боловч байгалийн нөөц баялгийг ард иргэдийн тусын тулд илүү сайн удирдах туйлын зорилгоо биелүүлэхийн тулд ил тод байдлаас хальж засгийн газрын зарлагыг илүү хариуцлагатайгаар удирдахыг хөхиүлэн дэмжих механизм бий болгохыг шаардаж байна. Ил тод байдал өөрөө эцсийн зорилго биш, харин төрийн хариуцлагатай байдлыг дээшлүүлж, улс орны байгалийн нөөц баялгийн үр шимийг аль болох олон хүмүүс хүртэх боломжийг дээшлүүлэх хэрэгсэл юм. Үүнтэй уялдан, компаниудаас төлж, засгийн газруудын хүлээн авч буй нөөцийн орлогын төлбөрийг иргэдэд ил тод, ойлгомжтой болгоход төдийгүй нөөц баялаг ихтэй орнуудын засгийн газрын орлогын хариуцлагатай, ил тод удирдлага, зарцуулалтыг хөхиүлэн дэмжихэд гол анхаарлаа хандуулах нь чухал.

Азербайжан, Чад, Зүүн Тимор, Мавритани, Сан Томе Принцип зэрэг ОУИТБС-д нэгдэн орсон хэд хэдэн оронд зарлагын удирдлагад илүү анхаарах болсон бөгөөд голдуу газрын тосны сан байгуулах замаар, зарим тохиолдолд тэдгээрийг удирдах эрх зүйн хүрээг бий болгох замаар хэрэгжүүлж байна. Газрын тосны сан болон зарлагын удирдлагын бусад механизм (хангалтгүй тохиолдолд) нь газрын тосны орлогыг хариуцлагатайгаар удирдах нөхцлийг бүрдүүлэхэд зайлшгүй чухал.

Тус санаачилгын туйлын зорилгыг биелүүлэхийн тулд зарлагын удирдлагад чиглэсэн механизмыг ОУИТБС-ын хажуугаар давхар бий болгох хэрэгтэй гэж Азербайжан, Конго-Браззавилле, Гана, Мавритани зэрэг улсын эвслийн гишүүд ярьж байлаа. ТН эвслийн гишүүний ярьсанчлан, Гана улсад засгийн газрын зарлагын тухай мэдээллийг тайлангийн маягтуудад оруулахаар бүр анхнаас нь тооцож боловсруулаад байгаа юм байна.

Ийнхүү ил тод, хариуцлагатай зарлагын удирдлагыг хөхиүлэн дэмжих механизм бий болгох чиглэлд хэрэгжүүлэгч засгийн газруудад дэмжлэг үзүүлэхийг ТН эвслийн зүгээс нийт оролцогчдод, нэн ялангуяа ОУИТБС-ын Удирдах зөвлөлд уриалж байна.

ДҮГНЭЛТ

ОУИТБС гарч эхэлснээс хойш дөрвөн жилийн хугацаанд нилээд ахиц дэвшил гараад байна. Уг санаачилгад нийт 21 улсын засгийн газар нэгдэн орсноос хоёр нь хөндлөнгийн хяналт хийлгэж, нэгтгэсэн тайлангаа гаргаж, нилээн хэдэн улс хэрэгжүүлэлтийн урьдач нөхцөл болсон үндсэн институциудээ бий болгоод байна. Уг санаачилгад чухал ач холбогдолтой зааврууд, шалгуурууд, удирдлагын бүтцүүдийг боловсруулах талаар ОУИТБС-ын Олон улсын зөвлөх бүлэг болон Нарийн бичгийн даргын газар ихээхэн ажил хийж гүйцэтгэсэн. Газрын тос, байгалийн хий, уул уурхайн олон компаниуд уг үйл явцад гоё үгээр төдийгүй зарим талаар практик дэмжлэг үзүүлж байна. Эцэст нь, ТН эвслээс ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үндэсний хүчин чармайлтыг дэмжихэд чиглэсэн дотоодын иргэний нийгмийн эвслүүдийг нэгдэн орсон орнуудад байгуулаад байна.

Янз бүрийн оролцогч талуудын энэхүү санаа нийлсэн хүчин чармайлтыг эс тооцвол, ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлэхэд төдийгүй түүний нөөц баялаг ихтэй орнууд дахь сайн засаглал ба хөгжлийн гол түлхүүр болсон орлогын ил тод байдлаар бүрэн хангах гэсэн туйлын зорилгоо биелүүлэх чадварт нь хэд хэдэн асуудал ихээхэн саад бэрхшээл учруулж байна. Тайланд орсон эдгээр хүндрэл бэрхшээлийн заримаас дурдвал, нэгдэн орсон хэд хэдэн засгийн газар иргэний нийгмийн байгууллагуудын голлох үүргийг хүлээн зөвшөөрч чадаагүй; иргэний нийгмийн идэвхтнүүдийг айлган сүрдүүлж, гадуурхсан; ОУИТБС-ыг хэрэгжүүлэх талаар авсан сайхан амлалт, тодорхой үйл ажиллагаа хоёрын хооронд ам, ажил зөрсөн; тухайн улсын түвшинд улс төрийн манлайлал сул, компаниудын оролцоо хангалтгүй байсан; хэрэгжүүлэгч засгийн газар, иргэний нийгмийнхэнд үзүүлэх техникийн болон санхүүгийн дэмжлэг хангалтгүй; ил тод байдлын шаардлагуудыг санхүүгийн стандарт механизмтай нэгтгэн уялдуулахад ахиц дэвшил бага гарсан явдал байлаа.

ОУИТБС-ыг өргөн хүрээтэй, амжилттай хэрэгжүүлэх нөхцлийг хангахын тулд нийт оролцогч талуудын зүгээс шинэлэг бөгөөд эрчимжүүлсэн идэвх чармайлт гаргах шаардлагатай болж байна. Энэ үүднээсээ энэхүү тайланд дурдсан 14 санал зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар ОУИТБС-ын шинэ Удирдах

зөвлөл, Нарийн бичгийн даргын газартай хамтран ажиллахыг ТН эвслээс нийт оролцогч талуудад уриалж байна. Эдгээр бодлого, өөрчлөлт нь олборлох салбарын орлогын “хяслан”-г төгсгөл болгож, тэдгээр орлогыг дэлхийн эргэн тойронд буй нөөц баялаг ихтэй орнуудын нийт ард иргэдийн хөгжил, цэцэглэлтийн эх үүсвэр болгон хувиргахад туслаж чадах юм.

ТАЙЛБАР

- 1 Ярилцлага авах боломжгүй байсан таван орны тоонд Чад, Экваторын Гвиней, Габон, Гвиней-Конакри, Негр улсууд оров.
- 2 Эдгээр алхмын заримыг «хийж дуусгасан явдал» нь тэдгээрийн чанарын баталгаа болохгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Жишээлбэл, Камерун, Казахстаны эвслийн гишүүд ажлын төлөвлөгөөний чанарын асуудлыг шүүмжилсэн бөгөөд эдгээр ганц хуудас баримт бичиг нь оролцогч талуудад хэрэгжилтийн талаар заавар удирдамж болохуйц хангалттай дэлгэрэнгүй биш байна гэж үзжээ.
- 3 Ялангуяа 2006 оны 8 сарын 31-нээс 9 сарын 1-ний хооронд Боннд болсон ОУИТБС-ын семинар дээр.
- 4 2006 оны 4 дүгээр сарын 6-нд Конгийн (Браззавилле) аюулгүйн хүчнийхэн Кристиан Моунзео, Брайс Макосо нарыг баривчилсан бөгөөд хожим нь залилан, хам залилан, хуурамчаар бичиг баримт үйлдсэн хэрэгт буруутгажээ. Эдгээр ял нь Моунзеогийн үүсгэн байгуулсан хүний эрхийн байгууллага болох Recontre pour le paix et les droits de l'homme (RPDH) байгууллагаас дээрх хоёр хүн хөрөнгө мөнгө завшсан гэсэн иргэний нэхэмжлэлтэй холбоотой байв. 2006 оны 6 дугаар сарын 2-нд анхан шатны шүүхээс хөрөнгө шамшигдуулсан тухай нотлох баримт олоогүй ба зөвхөн хуурамчаар баримт үйлдсэн гэсэн ялыг хэвээр үлдээсэн нь RPDH байгууллагын дансанд нэг гарын үсэг нэмсэнтэй холбоотой байсныг RPDH болон уг дансыг байршуулсан банкны зүгээс няцаасан боловч 2006 оны 6 дугаар сарын 13-нд дахин шүүх ажиллагааг эхлүүлсэн байна. 8 дугаар сард биднийг энэ тухай бичиж байх үед шүүх ажиллагаа үргэлжилж байсан бөгөөд Конгийн хууль тогтоомжууд төдийгүй БН Конго Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн конвенцуудыг зөрчиж байгаа нь улам бүр илэрхий болж байлаа. Эдгээр зөрчлүүдийн тоонд дур зоргоор цагдан хорьсон, зөвшөөрөлгүйгээр хууль бус нэгжлэг хийсэн, хэрэгтэй холбогдолгүй баримт бичгүүдийг хураан авсан, нотлох баримтгүйгээр хэрэг үүсгэсэн, хөрөнгө шамшигдуулсан ялыг хүчингүй болгох анхан шатны шүүгчийн шийдвэрийн эсрэг улсын прокуророос хуулинд заасан хугацаа өнгөрсөн хойно нэхэмжлэл гаргасан зэргийг хэлж болно.
- 5 Тухайлбал, АНУ-ын Төрийн Департамент, Ардчилал, Хүний Эрх, Хөдөмөрийн Товчооноос 2006 оны 3 дугаар сард гаргасан Хүний эрхийн практикуудын тухай орны тайлангууд 2005 /Country Reports on Human Rights Practices/-г үзнэ үү. <http://www.state.gov/g/drl/rls/hrrpt/2005/index.htm> хаягт байгаа.
- 6 Камерун ба Мавританий ЮТН эвслийн бүлгүүд эсэргүүцэл илэрхийлсний дараа хоёр улсын засгийн газрууд иргэний нийгмийнхэн нэмэлт төлөөлөгчдийг сонгохыг зөвшөөрсөн боловч Камерун улс хорооны гишүүдийнхээ бүрэлдэхүүнийг хараахан албан ёсоор шинэчлэн байгуулаагүй байна. Камерун дахь эвслийн гишүүний ярьж байгаагаар, хааяа эдгээр гишүүдийг хорооны хуралд урьж оролцуулахгүй байгаа нь асуудал үүсгэж байгаа ажээ.
- 7 Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын (ОУИТБС) Олон Хандивлагчийн Итгэлцэлийн Сан 2004 оны 8 дугаар сард байгуулагдсан бөгөөд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхийг эрмэлзэж буй орнуудад санхүүгийн туслалцаа үзүүлэх зорилготой. Энэ санг Дэлхийн Банк удирддаг. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.eitransparency.org/section/abouteiti/mdtf> хаягаар авна уу.

- 8 Avanzar LLC, EITI and the Mining Sector: Stakeholder Research Report /ОУИТБС ба уул уурхайн салбар: Оролцогч талуудын судалгааны тайлан/ (төсөл), хуудас 13. Энэхүү тайлангийн төслийг www.eitransparency.org хаягаар авч үзсэн.
- 9 Статойл компаний вэбсайтад байсан мэдээллээр тус компани орлого, татвар, цалингийн зардлуудаа нийтлэхээр төлөвлөж буй боловч нууцлалын заалтаас үүдэн «газрын тосны ашиг»-г нийтлэхгүй ажээ. http://www.statoil.com/INF/SVG_03595.NSF/UNID/23_AA3BC_F6C_F3_1_125713_E_002_EABB_5?OpenDocument хаягаар үзнэ үү.
- 10 Шелл компаний байр суурийг http://www.shell.com/home/Framework?siteId=envandsoc-en&FC2=/envandsocen/html/iwgen/key_issues_and_topics/our_contribution/payments_to_governments/zzz_lhn.html&FC3=/envandsocen/html/iwgen/key_issues_and_topics/our_contribution/payments_to_governments/our_approach_to_payments_to_governments_24042006.html. хаягаар үзнэ үү.
- 11 Хуулийн төслийг www.neiti.org хаягаар авсан.
- 12 «ОУИТБС-ыг байгуулах, түүний бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай Захирамж 1 2006, 001», 2006 оны 1 дүгээр сарын 12.
- 13 Тухайлбал, ОУСК-ийн Байгаль орчны болон нийгмийн тогтвортой байдлын бодлого (2006)-д «ОУСК нь дараахь зүйлийг шаардаж байна (i) олборлох үйлдвэрлэлийн томоохон шинэ төслүүдийн хувьд үйлчлүүлэгчээс хүлээн авагч засгийн газарт төлж буй төслийн материаллаг төлбөрүүдээ (нөөц ашигласны төлбөр, татвар, ноогдол ашиг гэх мэт) болон олон нийтийн анхаарал татсан гол гэрээнүүдийн холбогдох нөхцлүүдийг (хүлээн авагч засгийн газартай байгуулсан гэрээнүүд, засгийн газар хоорондын гэрээнүүд гэх мэт) олон нийтэд ил тод болгох; (ii) дээр нь, 2007 оны 1 сарын 1-нээс эхлэн ОУСК-аас санхүүжүүлсэн олборлох үйлдвэрлэлийн төслүүдийн үйлчлүүлэгчид эдгээр төслөөс хүлээн авагч засгийн газарт төлж буй материаллаг төлбөрүүдээ олон нийтэд ил тодоор тайлагнах ёстой» гэжээ.
- 14 IMF, Guide on Resource Revenue Transparency, /ОУВС, Нөөцийн орлогын ил тод байдлын тухай заавар/, 2005 оны 6 сар, хуудас 21.
- 15 Chris Baltimore and Tom Doggett, «More Oil Deal Disclosure Could Diffuse Disputes,» /Газрын тосны гэрээг илүү ил тод болгосноор маргаанаас сэргийлж болно/, Reuters, 2006 оны 8 дугаар сарын 29-ний бүтээлийг үзнэ үү.
- 16 Overseas Development Institute, «Sub-national Implementation of the Extractive Industries Transparency Institute (EITI)» /Далайн чанад дахь хөгжлийн институт, Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын үндэснийхээс доогуур түвшний хэрэгжилт/, ОУИТБС-ын Нарийн бичгийн даргын газарт болон Олон Улсын Хөгжлийн Департаментад зориулсан материал, 2006 оны 5 сар, хуудас vii.
- 17 дээрхтэй адил, хуудас viii.
- 18 Олон Улсын Зөвлөх Бүлэг, ОУИТБС-ын Олон Улсын Зөвлөх Бүлгийн төгсгөлийн тайлангийн төсөл, 2006/08/14, Санал зөвлөмж 5, хуудас 8.

Төлснөө нийтэл

Төлснөө нийтэл (ТН) эвсэл нь газрын тос, байгалийн хий, уул уурхайн үйлдвэрлэлийн салбараас нөөц баялаг ихтэй хөгжиж байгаа орнуудын засгийн газарт төлсөн орлогуудын төлөлт, хүлээн авалт, удирдлагыг бүрэн ил тод болгохын төлөө кампанит ажил явуулдаг. Голдуу авилга, зөрчилдөөн, хүн ардын зовлон зүдүүр өндөр түвшинд байдаг эдгээр орны тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах нэг үндэс бол байгалийн баялгийн орлого байх нөхцлийг бүрдүүлэхэд онцгой чухал эхний алхам бол ил тод байдлыг дээшлүүлэх явдал мөн. ТН эвслийг дэлхийн 50 гаруй орны авилгын эсрэг тэмцэл, хөгжил, байгаль орчин, хүний эрх, сүсэг бишрэлийн чиглэлээр ажилладаг 300 гаруй иргэний нийгмийн байгууллага, мөн Африк, Төв Ази ба Кавказ, Европ, Латин Америк, Хойд Америк, Зүүн Өмнөд Азийг хамарсан үндэсний иргэний нийгмийн эвслүүд дэмжиж ажилладаг.

www.publishwhatyoupay.org

Орлогын ажиглагч хүрээлэн

Орлогын Ажиглагч Хүрээлэн (Revenue Watch Institute-RWI)-ийн эрхэм зорилго бол байгалийн баялаг ихтэй орнуудын иргэдийг мэдээлэл, сургалт, сүлжээгээр хангаж, тэднийг олборлох үйлдвэрлэлээс засгийн газрынх нь олж буй орлого, түүний зарцуулалтад илүү үр нөлөөтэй хяналт шинжилгээ хийдэг болгоход шаардлагатай санхүүжилтээр хангах замаар дээрх орнуудын ардчилсан хариуцлагатай байдлыг дээшлүүлэх явдал юм. Байгалийн баялагт хөтлөгдсөн хөгжил нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж чадахгүй байх явдал хэтэрхий олон тохиолддог төдийгүй өсөлт буурах, ядуурал ихсэх, хүний хөгжил удаашрах, төрийн институциуд ялзарч сулрах, зарим тохиолдолд хүчирхийлэл, иргэний дайн өдөөхөд хүргэх явдал бүр ч олон байдгийг маш олон судалгаагаар харуулаад байна. Орлогын Ажиглагч Хүрээлэн нь нөөц баялгаас хамааралтай орнуудын төсвийн ил тод байдлыг хөхиүлэн дэмжих замаар олборлох үйлдвэрлэлээс бий болсон орлогууд тогтвортой өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулах нөхцлийг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байна.

www.renewatch.org

